



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • II • № 16



ЭРДЭНЭСИЙН САНГААС: ГАРХИН ХӨЛБЭРТЭЙ АЛТАН ЭЗЭМЭГ /хүннүгийн үе НТӨ III-III зуун/



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦЛИЙН 8 ЗАРЧИМ

- Хүртээмжтэй өсөлтийг бий болгох, орлогын тэгш бус байдал хэт өсөхөөс сэргийлэх. Бодит эдийн засаг болон инфляцийг тогтворжуулах,
- Засаглал, институцийг сайжруулж, чадавхийг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх,
- Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах, хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийх,
- Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх,
- Санхүүгийн хүчтэй салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох,
- Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай зүтгүүр хэд хэдэн компанийг дэмжин бий болгож, инноваци, технологийн дэвшлийг нутагшуулж ашиглах, эдийн засгийг төрөлжүүлэх,
- Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том том хөтөлбөрт багтаж орох, газар нутгийнхаа байршлын давуу талыг ашиглах,
- Байгалийн баялгаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, "Баялгийн ерөөл"-д хүрэх, байгаль орчноо сэргээн хамгаалах.

Монголбанкнаас санаачлан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах суурь зарчмуудыг санал болгох "Улаанбаатарын зөвшилцөл" чуулга уулзалтыг эрдэмтэн, судлаачид, төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулж, дээрх найман зарчмыг тунхаглахаар хэлэлцүүлэв.

Онцлох мэдээ:

ОУВС-аас өргөтгөсөн
санхүүжилтийн хөтөлбөрийн
хэрэгжилтийн гурав дахь
шатны үнэлгээг хийв

ХУУДАС

4

Индэр:

Гадаад валютын улсын
хангалттай нөөцтэй байх нь улс
орны тусгаар тогтнол, аюулгүй
байдал, үндэсний мөнгөн
тэмдэгтийн баталгаа мөн

ХУУДАС

6

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн
бага хурлаас... /2018.02.22/

ХУУДАС

11

Нийтлэл:

Эдийн засгийн тогтвортой
өсөлт, хөгжлийг бий болгох
бодлогын асуудалд

ХУУДАС

18

Байр суурь:

"Улаанбаатарын зөвшилцөл"-өөр
хэн юу хэлэв?

ХУУДАС

22

**Монголбанк юу
хийдэг вэ?**

Бодит мэдээлэл захын
оролцогчдад шуурхай хүрснээр
ханш бодитой тогтох боломж
нэмэгдэнэ

ХУУДАС

26

Орон нутаг

Завхан аймаг дахь Монголбанк

ХУУДАС

28

Дэлхийн эдийн засаг:

2011 оны нобелийн шагнал-Томас
Саргент, Кристофер Симс нарын
макро эдийн засгийн шалтгаан, үр
дагаварын талаар хийсэн эмпирик
судалгаа

ХУУДАС

31

Мөнгөн тэмдэгтийн түүх:

1939 оны мөнгөн тэмдэгт

ХУУДАС

33

Банкир:

Г.Амартүвшин: Ханшийн савалгаа
багасч, зээлийн хүү буурах болов
уу гэсэн хүлээлттэй байна

ХУУДАС

34

Судалгаа:

Блокчэйн технологи ба
криптовалют

ХУУДАС

38

Санхүүгийн боловсрол:


Та санхүүгийн хэрэглэгч болохын
хувьд зээлийн гэрээ байгуулахдаа
юунд анхаарах вэ?

ХУУДАС

42

БАНК ХООРОНДЫН ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг нэвтрүүлснээс хойш 2018/2/15-ны хооронд 294.6 сая ам.долларын, 77.8 сая юанийн арилжаа буюу нийт 306.2 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний гадаад валютын 534 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ ЭХНИЙ 2 САРД 1158 КГ-Д ХҮРЭВ

Монголбанк 2018 оны 2 дугаар сарын байдлаар 438.6 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 741 кг алт авч байснаас 302.4 кг-аар бага буюу 40.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.



2018 оны 2 дугаар сарын байдлаар Лондонгийн үнэт металлын захын алтны ханш бага байгаагаас шалтгаалан 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 102,833.87 төгрөг байлаа. Монголбанкны алт худалдан авах үнэ бага, алт олборлолтын хэмжээ бага байгаагаас шалтгаалан Монголбанкинд тушааж байгаа алтны хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ОУВС-аас өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн гурав дахь шатны үнэлгээг хийв

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн ажлын хэсэг 2018 оны 1-р сарын 24-өөс 2-р сарын 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж, Монгол Улсад хэрэгжиж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн гурав дахь үнэлгээг дүгнэж, Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний хэрэгжилт, тоон үзүүлэлтүүдэд урьдчилсан байдлаар дүгнэлт хийлээ. Тус дүгнэлтэд Монгол Улсын экспортолж буй гол түүхий эдийн эрэлт нэмэгдэж, эдийн засагт итгэх итгэл сайжирч байгаатай холбоотойгоор эдийн засаг сэргэж, макро эдийн засгийн гол зорилтот үзүүлэлтүүд, түүний дотор төсвийн алдагдал, гадаад валютын нөөцийн зорилтот түвшинг их хэмжээгээр давуулан биелүүллээ. Мөн Банкны системийг бэхжүүлэх, татварын боловсронгуй тогтолцоог бий болгох, төсвийн хяналтыг сайжруулах асуудалд ойрын хугацаанд анхаарлаа үргэлжжүүлэн хандуулах нь зүйтэй гэж онцолжээ.


...

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар даатгалын салбарт эрх зүйн шинэчлэлт хийх саналыг дэмжив

Санхүүгийн тогтвортой байдлын

зөвлөлийн ээлжит хуралдаан Сангийн яамны хурлын танхимд 2018 оны 2 дугаар сарын 9-нд болов. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө, Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох санал, зөвлөмжийг тусган Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлахаар тогтов. Түүнчлэн даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яамны хамтарсан ажлын хэсгийг байгуулах саналыг хуралдаанаар дэмжив.

...



Банкны активын чанарын үнэлгээгээр Монгол Улсын банкны салбар тогтвортой хэмээн үнэлэгдэв

ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Монгол Улсын арилжааны банкуудын активын чанарын үнэлгээг олон улсад нэр хүнд



бүхий, хөндлөнгийн аудитын компаниар хийлгэх үүргийг Монголбанк хүлээж, гүйцэтгэгчийг хууль тогтоомжид заасан журмын дагуу сонгон шалгаруулснаар Бүгд Найрамдах Чех Улсад бүртгэлтэй, PricewaterhouseCoopers Česká republika s.r.o. компанитай 2017 оны 8 дугаар сард гэрээ байгуулж, активын чанарын үнэлгээ хийх ажлыг эхлүүлсэн билээ. Активын чанарын үнэлгээгээр банкуудын зээлийн багцын чанарыг үнэлэхээс гадна тэдгээрийн үйл ажиллагааны бодлого, журам, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, барьцаа хөрөнгө, гуравдугаар түвшний хөрөнгө зэргийг үнэлэх ажиллагаа хийгдлээ. Үнэлгээгээр банкуудын зээлийн эрсдэлийн удирдлага, барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой нөхцөл, шаардлагыг сайжруулах шаардлагатай гэж үнэлэгдсэн ч төлбөрийн чадварын хувьд Монгол Улсын банкны салбар бүхэлдээ тогтвортой байна гэж Олон Улсын хөндлөнгийн аудитын байгууллага дүгнэлээ.

...

Орон нутгийн сэтгүүлчдэд эдийн засгийн мэдлэг олгох сургалтыг жил бүр зохион байгуулна

Монголбанк Орон нутгийн сэтгүүлчдийн холбоотой хамтран Төв банкны үйл ажиллагааг танилцуулах

сургалт, уулзалтыг зохион байгуулав. Сургалтад орон нутгийн сэтгүүлчдийг төлөөлж 50 гаруй сэтгүүлч хамрагдлаа. Монголбанк 2017 онд хэрэгжүүлсэн орон нутгийн бүсчилсэн уулзалтаар сэтгүүлчид болон иргэдэд зориулсан цуврал сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэ удаад өөрийн төв байрандаа анх удаа сургалт уулзалтыг зохион байгуулсан юм. Хүрэлцэн



ирсэн нийт сэтгүүлчдэд зориулж, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн мэндчилгээ дэвшүүлж, Монголбанкны газар хэлтсийн захирлууд Монголбанкны үндсэн үйл ажиллагаа, хууль эрх зүйн шинэчлэл, гадаад валютын ханшид Монголбанк хэрхэн оролцдог болох, Монголбанкны алт худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аяны хэрэгжилт зэрэг сэдвээр мэдээлэл өгч, сонирхсон асуултуудад нь хариулт өглөө.

...

Банк хоорондын их дүнтэй гүйлгээний "RTGS - /Банксүлжээ/" системийн II үеийн шинэчлэлийг нэвтрүүлэв

Монголбанк, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн "RTGS- /Банксүлжээ/ системийн II үеийн шинэчлэл" дэд төслийг амжилттай

хэрэгжүүлснээр банк хоорондын их дүнтэй гүйлгээний RTGS /Банксүлжээ/ систем 2018 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр системийн II хувилбарт бүрэн шилжлээ. Уг систем шинэчлэгдсэнээр банк хоорондын их дүнтэй гүйлгээнд дараах давуу талууд бий болов. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмж талаасаа илүү олон нөөц сервертэй болсноор системийн тасралтгүй ажиллагаа болон найдвартай байдал нэмэгдэв.



- Гүйлгээг дамжуулах хурд, өдөрт дамжуулах гүйлгээний тоо, чадамж өмнөхөөсөө гурав дахин илүү болов.
- Системийн програм хангамж шинэчлэгдсэнээр банк хоорондын их дүнтэй гүйлгээг зохицуулахад илүү хялбар болов.
- Системийн мессежийн бүтэц I SO20022 стандарт, олон улсад мөрдөгддөг IBAN дансны дугаарлалтад шилжсэн зэрэг юм.



ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН ХАНГАЛТТАЙ НӨӨЦТЭЙ БАЙХ НЬ УЛС ОРНЫ ТУСГААР ТОГТНОЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН БАТАЛГАА МӨН

*“Улаанбаатарын зөвшилцөл” хэлэлцүүлгийг нээж,
Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы хэлсэн үг*

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье.

Бидний санаачилгыг дэмжин урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд Монголбанкны Ерөнхийлөгчийн хувиар гүн талархал илэрхийлье!

Гурван долоо хоногийн өмнө бид ирээдүйн “Монголын Давос” болох “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган”-ыг Эрдэнэт

хотноо “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” сэдвийн дор амжилттай зохион байгуулж Монголын эдийн засгийн энэ жилийн өнгө аясыг тодорхойлсон. Тус чуулганаар бид улс орныхоо эдийн засаг, санхүүгийн салбарт ойрын хугацаанд шийдвэрлэх асуудлуудыг ярилцан, нэгдмэл зорилтуудаа тодорхойлж чадсан.

Харин өнөөдөр бид Монгол

Улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох бодлогын жор болох учиртай “Улаанбаатарын зөвшилцөл/Ulaanbaatar Consensus/-ийг санал болгон хэлэлцүүлж, Та бүхний үнэтэй саналыг тусгахыг зорьж байна.

Миний бие Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн шийдвэр гаргах, бодлого боловсруулах, соён гэгээрүүлэх чиглэлээр олон жил ажиллаж, хичээн зүтгэж ирэхдээ хуримтлуулсан мэдлэг, туршлага, санал бодлоо нэгтгэн, өөрийн санаачлан үүсгэн байгуулсан “Мөнгө, санхүү, баялаг” судалгаа шинжилгээний сэтгүүлээр дамжуулан “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төслийг санал болгон эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчдын оюуны сонорт хүргэсэн билээ. Монголбанк уг хэлэлцүүлгийн индэр болоход бэлэн байгаагаа уламжилсны дагуу өнөөдрийн энэ үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Монгол Улсад сүүлийн 300 гаруй жил эдийн засгийн бие даасан бодлого байсангүй гэхэд болохоор байгаа юм. 1636-1911 оны хо

баталгаажуулан Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, Богд Жавзандамба хутагтыг хаан ширээнд залж, таван яам бүхий Засгийн газрыг байгуулах түүхэн шийдвэр гаргасан. Богд хаант Монгол Улсын Засгийн Газар нь Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яам, Цэргийн яам, Сангийн яам, Шүүх яам болон Дотоод явдлын яам хэмээх таван яамнаас бүрдэж байв. Ерөнхий сайдаар Сайн Ноён хан Намнансүрэн анх томилогдсон. Харамсалтай нь анхны таван яамны Шүүх яамнаас бусад дөрвөн яамны сайд нар 1914-1915 онд бүгд учир битүүлгээр амиа алдсаныг түүх өгүүлдэг.

1921 оны Ардын хувьсгалын ялалтын үр дүнд харийн түрэмгийлэгчдийг эх орноосоо хөөн гаргаж, феодалын байгууллыг халж, Ардын эрхт хэмжээт цаазат Монгол Улсыг тунхагласан. Үүнээс хойших 70 жилд Монгол Улс улс төр, эдийн засаг, худалдаа, цэрэг, геополитикийн аливаа бодлого дээр Зөвлөлт Холбоот Улсын амыг харж тусламж дэмжлэгт нь дулдуйдаж иржээ. Энэ түүхэн зурвас үед Монгол Улсын орчин үеийн эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын үндэс суурь тавигдаж, тусгаар тогтнолоо дэлхийн олон улс орноор хүлээн зөвшөөрүүлж, хүн амаа өсгөн олшруулсан юм.

Ардчилсан хувьсгалын дараагаас манай улс ардчилал, чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний он жилүүдэд буюу 1991-1993 оны хооронд эдийн засаг жилд дунджаар 7 орчим хувь унасан билээ. Энэ үеэс л олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудын тусламж, дэмжлэгийг авч эхэлсэн. Тухайлбал, Монгол Улс 1991 оны 2 дугаар сарын 14-ний өдөр

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-д элссэнээс хойших 27 жилийн хугацаанд ОУВС-ийн хөтөлбөрийг 6 удаа авч, нийт 13 жилд нь тус сангийн хөтөлбөртэй хамтран ажилласаар өнөөдөртэй золголоо. Тухайлбал,

-1991 оны 10 дугаар сарын 4-ний өдөр “Стэнд бай” хөтөлбөрийг нэг жилийн хугацаатай авч хэрэгжүүлснээр донор орнуудын зээл, тусламжийг ашиглах нөхцөлийг бүрдүүлж байв.

-ОУВС-ийн “Enhanced Structural Adjustment Facility (ESAF)” хөтөлбөрийг 1993 оны 6 дугаар сараас 1996 оны 6 дугаар сарын хооронд 3 жилийн хугацаатай,

-ОУВС-ийн “ESAF 2” хөтөлбөрийг 1997 оны 6 дугаар сараас 2000 оны 6 дугаар сарын хооронд 3 жилийн хугацаатай,

-Яду



бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх,

- Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах, хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийх,
- Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх,
- Санхүүгийн хүчтэй салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох,
- Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай зүтгүүр хэд хэдэн компанийг дэмжин бий болгож, инноваци, технологийн дэвшлийг нутагшуулж ашиглах, эдийн засгийг төрөлжүүлэх,
- Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том том хөтөлбөрт багтаж орох, газар нутгийнхаа байршлын давуу талыг ашиглах,
- Байгалийн баялгаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, "Баялгийн ерөөл"-д хүрэх, байгаль орчноо сэргээн хамгаалах зэрэг асуудлыг дурдаж болно.

Энэхүү зөвшилцөл нь улс төрийн орчноос үл хамааран Монгол Улсын хөгжлийн бодлогод тогтвортой хадгалагдан хэрэгждэг байгаасай хэмээн бид хүсч байгааг энд онцлон

дурдмаар байна.

Иймээс Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид та бүхнээс Монгол орны тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх зам болох учиртай "Улаанбаатар зөвшилцөл"-ийн төслийг улам боловсронгуй болгоход эрдэм оюунаа дайчлан, хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

Морилон ирж буй "Тийн унжлагат хэмээх шар нохой" жилдээ "Улаанбаатар зөвшилцөл"-ийг тунхаглан зарлаж, сахин

ВАЛЮТЫН ХАНШ

- Ханш хэрхэн тогтдог вэ?
- Ханшийн дэглэм
- Монголбанк ханшийг зарлана харин тогтоохгүй

1

Ханш хэрхэн тогтдог вэ



Эрэлт, нийлүүлэлт
иргэдийн хүлээлт гэх мэт



Болон



Гадаад
Валют

Орох урсгал



Гадаад
Валютын Нөөц



Гарах урсгал

Төлбөрийн тэнцэл,
Гадаад валютын нөөц

2

Ханшийн дэглэм



3

Монголбанк ханшийг зарлана харин тогтоохгүй

Ханш тогтох

- Банк, Банк бус санхүүгий байгууллагууд нь өөрсдийн ханшийг тогтооно.

Зориулалт:

- Гадаад валют худалдаж авах,
- Гадаад валют зарах,
- Хэлцлийн ханш гэх мэт.



	2018 оны 02 сарын 27. 11:52	
USD АНУ-ын доллар	Авах ↑	Зарах ↑
Уран уургагч	2,393.00	2,396.00
ХААН	2,391.00	2,400.00
ХХБанк	2,391.00	2,400.00
Төрийн банк	2,394.00	2,404.00
Голломт	2,393.00	2,398.00

Ханш зарлах

- Монголбанк нь банкуудын арилжааны дундаж ханшийг тооцож, зарлана.

Зориулалт:

- Нягтлан бодох бүртгэл,
- Гааль, шүүх, татвар, шимтгэл, хураамж, төлбөр ноогдуулах гэх мэт.



2018 оны 2 сарын 26 өдрийн хаягтын ханш

АНУ доллар	2,395.93
Евро	2,952.38
Японы иен	22.49
БНХАУ-ын хань	379.85
БНСУ-ын won	2.23
Английн фунт	3,561.73

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

1

Төлбөрийн тэнцэл гэж юу вэ?



“Төлбөрийн тэнцэл” гэж аливаа улсын эдийн засгийн харьяатын гадаад эдийн засагтай буюу эдийн засгийн харьяат бустай тодорхой хугацаанд хийсэн худалдаа, үйлчилгээ, хөрөнгө, санхүүгийн болон бусад урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайлан

Орох урсгал



Гарах урсгал



Төлбөрийн тэнцэл

- Экспортын орлого

Зэс, нүүрс, алт,
түүхий нефть...

- Зээл, бонд
- Гадны тусламж
- ГШХО

- Импортын төлбөр

Бензин, тоног төхөөрөмж,
хүнс...

- Үйлчилгээний
төлбөр

Тээвэр, аялал, эмчилгээ,
санхүүгийн үйлчилгээ...

- Зээл, бондын
төлбөр
- Хүүгийн төлбөр

Төлбөрийн тэнцэл ашигтай
буюу зерэг гарвал "Гадаад
валютын цэвэр нөөц"
нэмэгдэнэ

Төлбөрийн тэнцэл
алдагдалтай буюу сөрөг
гарвал "Гадаад валютын
цэвэр нөөц" хасагдана

2

Монгол Улсын төлбөрийн тэнцэл /2017 оны 12-р сар/

Урсгал ба хөрөнгийн дансны
тэнцэл

Санхүүгийн дансны тэнцэл

Нийт төлбөрийн тэнцэл

Алдагдалтай

907.1 сая \$

Хөрөнгө оруулалтын алдагдал өссөн

Ашигтай

2439.0 сая \$

Хөрөнгө оруулалтын орлого өссөн

Ашигтай

1459.9 сая \$

ГВАН 3,008.2 сая \$

Урсгал ба хөрөнгийн данс

Бараа

Ашигтай
1,474.2 сая \$



Үйлчилгээ

Алдагдалтай
1207.4 сая \$



Анхдагч орлого

Алдагдалтай
1,430.1 сая \$



Хоёрдогч орлого

Ашигтай
178.9 сая \$



Санхүүгийн дансны гүйцэтгэл

Шууд ХО

Ашигтай
1325.7 сая \$

Багц ХО

Ашигтай
471.4 сая \$

Санхүүгийн ҮХ

Алдагдалтай
17.3 сая \$

Бусад ХО

Ашигтай
659.2 сая \$



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... /2018.02.22/

Монголбанкны сар тутмын хэвлэлийн бага хурал 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр болж, 1-р сарын статистик үзүүлэлт, банкны активын чанарын үнэлгээний үр дүн, Монголбанкнаас хэрэгжүүлж буй “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аян” болон холбогдох бусад цаг үеийн асуудлаар мэдээлэл өглөө.

lkon.mn: ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдснаар арилжааны банкуудад шалгалт хийсэн. Үнэлгээний үр дүнгээр банкны систем тогтвортой байна гэж гарсан талаар мэдээлж байна. Гэхдээ банкуудын байдал харилцан адилгүй, зарим банк харьцангуй муу үнэлгээ авсан гэх мэдээлэл бас гарч байна. Энэ талаар тодруулна уу?

Хяналт, шалгалтын газрын захирал Н.Батсайхан:

-Активын чанарын үнэлгээний үр дүнгээр банкны системийн хэмжээгээр ДНБ-ий 2 орчим хувьтай тэнцэх хэмжээний өөрийн хөрөнгийн дутагдал гарсан. Гэсэн хэдий ч банкны системийн үзүүлэлт сайн байгаа. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 13.7 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 45 хувьтай байна. Тийм учраас систем энэ зэргийн дутагдлыг даваад гарчих бололцоотой гэж үзэж байгаа. Том, жижиг банкууд өөр өөр дүнтэй гарсан гэх мэдээллийн тухайд бол, Монголбанкны зүгээс банкны системийн нийт дутагдлын тухай л олон нийтэд мэдээлнэ. Тэгэхээр банк тус бүр дээр мэдээлэл өгөх боломжгүй юм.

МНС ТВ: УИХ-аар төв банкны тухай болон банкны тухай хууль батлагдсан. Энэ үеэр зээлийн хүүнд хязгаар тогтоох асуудал яригдаж байсан. Гэхдээ зээлийн хүүг хатуу тогтоохгүй, бууруулах талаар ажлын хэсэг байгуулагдсан байсан. Ажлын явцын ямар байна вэ?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Төв банкны тухай болон Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үеэр энэ асуудал нэлээд яригдсан. Яг өргөн баригдсан хуулиудад зээлийн хүүг тогтоох асуудал тусгагдаагүй. Харин дагалдах хуулинд тусгасан байсныг Улсын Их Хурлын гишүүд хэлэлцүүлгийн явцад дэмжээгүй. Гэхдээ Эдийн засгийн

байнгын хороон дээр зээлийн хүүг бууруулах шийдлийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Удахгүй үр дүн нь гарах байх.

Өдрийн сонин: Олон нийтэд системийн дутагдлыг мэдээлээд, банк тус бүрийн асуудлыг мэдээлэхгүй гэж байна. Үүнийг тодруулна уу. Нөгөөтэйгүүр активын чанарын үнэлгээний үр дүн эхний байдлаар гарсан ч 2017 оны 3-р улирлаар тохируулга хийгдэнэ гэж байсан. Анх гарсан үр дүнгээ шууд мэдээлээгүй, дээр нь одоо зөвхөн системийн ерөнхий мэдээллийг өгнө гэхээр хардлага төрүүлээд байна л даа?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Активын чанарын үнэлгээг 2016 оны эцсийн тайлан, тоонд үндэслэж хийсэн. Энэ нь эдийн засгийн мөчлөгийн хувьд нэлээд муу жил байсан. Активын чанарын үнэлгээг хийх сонгон шалгаруулалт, бэлтгэл ажил хангах гэх зэргээр үнэлгээг дөрвөн сарын дотор хийж гүйцэтгэсэн. Нэлээд хугацаа орсон учраас энэ явцад материаллаг өөрчлөлтүүд банкуудад гарсан. 2017 он гараад эдийн засагт сэргэлт бий болсон. Тийм учраас активын чанарын үнэлгээнд тохируулга хийх ёстой гэж үзсэн. Ингээд 2017 оны гуравдугаар улирлаар гарсан өөрчлөлтүүдийг тусгаад, эцсийн дүнг гаргасан. Саяын танилцуулсан дүн бол тохируулгын дараах эцсийн үр дүн.

-Системийн дутагдал гэдэгт юу юу орох вэ?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Банкны системийн өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээ юм. Активын иж бүрэн үнэлгээний гол зорилго нь хэчнээн хэмжээний өөрийн хөрөнгийн дутагдал байна вэ гэдгийг л илрүүлэх зорилготой. Тэгэхээр

банкууд маань энэ хэмжээгээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай.

Ийгл ТВ: ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд орж ирж байгаа мөнгө юунд зарцуулагдах вэ. Монголбанкнаас үүнд ямар оролцоотой байгаа вэ?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад санхүүжилт олгохоор ОУВС болон дагалдах донор улсууд орж ирж байгаа. Нийт хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан мөнгөн дүн нь 5.5 тэрбум ам.доллар. Үүнээс ОУВС 550 сая ам.доллар. Яг сангаас орж ирж байгаа энэ зээл нь зарцуулагдахгүйгээр төв банкны тэнцэл дээр байдаг. Ингээд хөтөлбөр хэрэгжээд дууссаны дараа төлөгддөг.

Zaluu.com: Ипотекийн зээлийн урьдчилгааг 25 хувь, хүүг 7 хувь болгох тухай мэдээлэл гарсан. Үүн дээр Монголбанк ямар оролцоотой байгаа вэ. Зээлийн урьдчилгаа төлбөр, хүүг бууруулах бодит боломж байгаа юу, ипотекийн зээлийн жилийн 8 хувийн хүү олон улсын түвшинтэй харьцуулахад өндөр үү?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин:

-Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Монголбанкны зүгээс 2018 оны есдүгээр сар гэхэд хөтөлбөрийг Засгийн газарт бүрэн шилжүүлэхээр ажиллаж байна. Харин Засгийн газар ипотекийн хөтөлбөрийг цаашид хэрхэн үргэлжлүүлэх, хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг дээр Дэлхийн банкнаас авсан зөвлөмжийн дагуу хэд хэдэн санал гаргаад журамдаа тусгаж байгаа юм билээ. Одоогоор журмаа эцэслэн тогтоогүй байгаа. Зарим мэдээллээр урьдчилгааг 25 хувь болгох, дахин суурьшлын бүсэд зээл авсан бол хүүг нь бууруулна гэх зэрэг саналууд явж байна. Монголбанк энэ журамтай танилцаад, саналаа өгсөн. Одоогийн байдлаар ипотекийн зээлийн хөтөлбөр Монголбанкны эзэмшиж буй ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрөөс сан үүсгээд, үүнийгээ банкуудад хуваарилаад явж байгаа. Нэг, хоёрдугаар сард тус бүр 16.6 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. Засгийн газраас энэ онд 120 тэрбум төгрөгийг ипотекийн зээл олгоход төсөвт суулгасан. Зээлийн хүүний түвшний хувьд төв банкны үнэт цаасны хүү 11 хувь байгаа. Тэгэхээр 8 хувь нь Монголын хувьд харьцангуй бага түвшин.

Ikop.mn: Активын чанарын үнэлгээний дараа өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хугацаатай

даалгаврыг банкуудад өгнө гэж байсан. Энэ даалгаврыг өгсөн үү?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Активын чанарын үнэлгээний дараа стресс тест хийгдэнэ. Яагаад гэвэл хөтөлбөр хэрэгжиж дуустал банкны систем эрүүл байх шаардлага бий. Стресс тест гэдэг маань ирээдүйд чиглэсэн "дасгал" гэж ойлгож болно. Үүний үр дүнд банкуудад өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавигддаг. Тэгэхээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагыг бүх банкуудад тавина. 2020 он хүртэл эдийн засаг ямар байх сценарийг банкуудад өгсөн. Банкууд үүний дагуу бизнес төлөвлөгөө болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө Монголбанкинд ирүүлнэ. Эцсийн тоог гуравдугаар сардаа багтааж Монголбанк тогтооно.

МҮОНТ: Статистик мэдээллээс харахад Засгийн газрын өр нэмэгдсэн байна. Өнгөрсөн онд Засгийн газар хоёр ч удаа бонд гаргаж, өрийг өрөөр дарсан. Гэсэн хэдий ч өр дахиад нэмэгдсэн байгаагийн шалтгаан юу вэ?

Судалгаа статистикийн газрын Статистикийн хэлтсийн захирал Б.Батсүрэн:

-Засгийн газрын гадаад өрийн мэдээллийг бид Монгол Улсын нийт гадаад өрийн статистик мэдээллийг гаргах зориулалттайгаар Сангийн яамнаас авч, мэдээлдэг. Тэгэхээр ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд орж ирж байгаа зээл, бусад хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотойгоор Засгийн газрын өр нэмэгдэж байгаа.

МҮОНТ: Засгийн газрын зээлүүд хэр зэрэг хямд өртөгтэй орж ирж байгаа вэ?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Засгийн газар өнгөрсөн онд хоёр ч бонд гаргасан. Үүний хүү нь маш багаар гарсан. Өмнө нь Засгийн газрын бондын хүү хоёр оронтой тоо руу орсон байсан. Хөтөлбөрт орж, Монголбанк Засгийн газартай хамтран ажилласнаар хүүг бууруулж, нэг оронтой тоо руу оруулж чадсан. Улмаар Монгол Улс хугацаа нь тулсан өр, төлбөрүүдээ дахин санхүүжүүлсэн. Хөтөлбөрийн зээлийн хувьд харьцангуй маш бага хүүтэй байгаа.

НУСЗЗГ-ын захирал А.Энхжин:

-Хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлийн хүүгийн талаарх мэдээллийг та бүхэн тус байгууллагын цахим хуудаснаас авч болно. Засгийн газрын бондын хувьд Н.Батсайхан захирлын хэлсэнчлэн ОУВС-ийн хөтөлбөрт орохоос өмнө Засгийн

газрын бондын хүү 13 орчим хувьтай, Хөгжлийн банкны бондын хүү бараг 40 хувьд хүрч байсан. Гэтэл сүүлд гаргасан Засгийн газрын бондын хүү 5.5-5.6 хувийн л хүүтэй байна. Тэгэхээр бид хэдийгээр өрийг өрөөр дарж байгаа ч хүүгийн зардал нь буурч байгаа. Үүнийг дагаад төсөвт ирэх дарамт нь ч бас буурч байгаа.

МҮОНТ: Чанаргүй зээл уул уурхайн салбарт өндөр байгаагийн шалтгаан нь юу вэ?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Монгол Улсын эдийн засгийн мөчлөгтэй хамааралтай. Манай экспортын түүхий эдийн үнэ буурахаар тухайн салбарт ажиллаж байгаа компаниудад санхүүгийн хүндрэл учраад, банкуудаас авсан зээлээ төлөхөд асуудал үүсч байгаа. Эргээд уул уурхайн салбарт сэргэлт ажиглагдаад эхлэнгүүт тухайн компанийн үйл ажиллагаа ч бас сайжирч байгаа юм.

"Үндэсний шуудан" сонин: Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний данс 1.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан гэж байна. Эдийн засаг өсч байхад яагаад ийм их алдагдал гарсан юм бол?

ССГ-ын Статистикийн хэлтсийн захирал Б.Батсүрэн:

-Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний данс алдагдалтай гарч байгаа нь тээврийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.

НУСЗГ-ын захирал А.Энхжин:

-Эдийн засаг сэргэхээр худалдааны хэмжээ нэмэгдэж байгаа. Экспорт, импорт ч өсч байгаа. Манай Монгол Улс дэд бүтэц муу учраас тээврийн зардал өндөр гардаг шүү дээ. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн идэвхжлийг дагаад төлбөрийн тэнцлийн үйлчилгээний данс алдагдал хүлээж байгаа.

Gogo.mn: АТМ-ээс мөнгө авахад иргэд 500 төгрөгийн шимтгэл авч байгаад иргэд их бухимдалтай байдаг. Үүн дээр Монголбанк оролцож, зохицуулах боломж байна уу?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-Хоёр банк хоорондоо гүйлгээ хийхэд тодорхой техник, технологи хэрэгтэй. Хөрөнгө оруулалт хийнэ. Тэнд ажиллаж байгаа техник, технологи, ИТ шийдэл, хүний нөөц гээд тэр бүхэнд л зориулж авч байгаа төлбөр. Үнэгүй зүйл гэж байхгүй.

Gogo.mn: Активын чанарын үнэлгээн дээр манай 14 банк бүгдээрээ хангалтгүй байсан учраас өөрийн хөрөнгийн хүрэлцээ дутагдсан гэж ойлгож болох уу. Яагаад 14 банк бүгдээрээ гэрийн даалгавар

авахад хүрэв?

ХШГ-ын захирал Н.Батсайхан:

-14 үүлээ хангалтгүй дүгнэгдсэн асуудал огт гараагүй. Дахин хэлэхэд стресс тест хийгдэнэ. 2020 он хүртэл Монгол Улсын эдийн засаг хэрхэн хөгжих вэ гэдэг сценариа ОУВС-тай тохирсон. Үүний дагуу банкууд ажиллавал хэчнээн хэмжээний өөрийн хөрөнгө хэрэгтэй вэ гэсэн асуултад банк болгон хариулна. Үүнийг л хэлээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, ирээдүй рүү, урагшаа харсан дасгал хийх юм. Активын чанарын үнэлгээний үр дүнгээр бүгдэд нь дутагдал гараагүй.

МонЦаМэ: Статистик мэдээллээ гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа дүн харагдаж байна. Хөрөнгө оруулалтын ихэнх нь уул уурхайн салбарт төвлөрч байгаа байх. Цаашдаа хөрөнгө оруулалт нэмэгдэх нөхцөл, боломж хэр харагдаж байна вэ. Уул уурхайгаас гадна бусад салбарын хөрөнгө оруулалт ямар түвшинд байна вэ?

НУСЗГ-ын захирал А.Энхжин:

-Засгийн газрын үнэт цаасны хүү олон улсын зах зээл дээр харьцангуй буурсан. Мөн Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг саяхан В3 болгож нэмэгдүүлсэн. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж байгаа. Үүнийг дагаад хөрөнгө оруулалт ч бас нэмэгдэж байна. Мэдээж энэ онд орж ирэх хөрөнгө оруулалтын ихэнх нь уул уурхайн салбарт төвлөрөх болов уу гэж бодож байна. Гэхдээ үүний хажуугаар бусад салбарт ч бас хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа. Саяхан гарсан мэдээллээр бол нэг компани IPO хийгээд, түүнд нь Солонгосын компани хөрөнгө оруулалт хийсэн. Тэгэхээр уул уурхайн салбарыг дагаад бусад салбарын хөрөнгө оруулалт ч бас нэмэгдэж байгаа.

NTV ТВ: Ипотекийн зээлийн эргэн төлөлт дээр зээлийн үндсэн төлбөр бараг төлөгдөхгүй, хүү маш өндөр байна гэх гомдол их байдаг. Үүнийг шийдэх арга байдаг уу?


НУСЗГ-ын захирал А.Энхжин:

-Банкууд олгосон зээлэндээ хүүгээ яаж тооцож авдаг вэ гэхээр тухайн хүн тухайн сардаа ямар хэмжээний зээлтэй байна, тэрэнд нь таарсан хүүг авдаг. Тэгэхээр төлбөрийг нь сар бүр тэнцүү байхаар хуваахад эхний ээлжинд яах аргагүй тухайн хүний авсан зээлийн дүн өндөр байгаа учраас хүү нь өндөр гардаг. Энэ нь явцдаа хүү үндсэн төлбөрийн байр солигдоод явах юм. Банкууд илүү хүү авч байна гэж ойлгож болохгүй.


Статистикийн тойм

Мөнгөний нийлүүлэлт 15.8 их наяд ₮

M2-г эзлэх хувиар




M1, M2, нийт зээлийн жилийн өсөлт /хад.байгууллагуудаар/



Нийт зээл 13.5 их наяд ₮ /16 банкаар/

M2-г эзлэх хувиар




Банкуудын нийт зээлд эзлэх хувь




Чанаргүй зээл 8.8%

Хугацаа хэтэрсэн зээл 6.9% /14 банкаар/



Зээлийн хүү: ₮ 19.4% \$ 10.8%



Ипотекийн зээл 4.3 их наяд ₮, зээлдэгчдийн тоо 93147




Зураг 1. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь




96.0% хэвийн, 2.2% хугацаа хэтэрсэн, 1.8% чанаргүй зээл байна.

Зураг 2. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон дундаж зээл




Нэг зээлдэгчид дунджаар 70.3 сая төгрөг, Улаанбаатар хотод 80.4 сая төгрөг, орон нутагт 44.2 сая төгрөг байна.

Зураг 3. Барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Ипотекийн зээлийн үлдэгдлийн 60.3% буюу 2.6 их наяд төгрөгөөр 2011-2015 онд ашиглалтанд орсон орон сууц худалдан авчээ.

Зураг 4. Барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ




Зураг 5. Зээлдэгчийн орлого



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.8% буюу 3856.9 тэрбум төгрөг 80м² хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.


Нийт зээлдэгчдийн тоо 93191 байгаагийн 64.1% нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой, 73.0% нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авчээ.

Зураг 6. Зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл



Нийт зээлдэгчдийн 75.9% нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.7 хувийг эзэмшиж байна.


Зураг 7. Хамтран зээлдэгчийн тоо



Нэг хамтран зээлдэгчтэй зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.4% буюу 3416.4 тэрбум төгрөгийн зээлийг эзэмшиж байна.



3. Гадаад өрийн статистик, 2017.IV улирал



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

АЛТАН ТОНОГТОЙ ХЭТ ХУТГА

ХОСГУЙ ҮНЭТ
ХІХ-ХХ ЗУУНЫ ЭХЭН
ДОЛОННУУР ХИЙЦ

Жин: 1384.2 гр

Хутга: 34.5 см

Хуй: 24.5 см

Хэт: 11x7 см



ХVII-ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ЭДИЙН ГОЁЛ

Монголд ХІХ зууны сүүлч ХХ зууны эхэн гэхэд Далай Чойнхор вангийн ган сийлбэр эдлэл, Дарьгангын мөнгөн хийц, Хүрээний болоод Боржигон, Батноров хийцийн цутгуур зэрэг өвөрмөц ур хийцүүд бий болж, монгол уламжлалт дархны урлалыг улам баяжуулан хөгжүүлсэн байна. Түүний нэг төлөөлөл нь энэхүү хэт хутга юм.

Хуй болон хутганы бариулыг хүрэн суман модоор хийж, тоног чимэглэлийг алтаар цутган урлаж, цоолбор хээ чимэг гаргасан. Хэт хутгыг бэлтэй цацагтай сүлжмэл уяагаар холбосон бөгөөд тайлах, зүүхэд хялбар болгох зорилгоор бэлний суранд нарийн хийцтэй төмөр түгжээ хийсэн байна.

**Н.БАЯРТСАЙХАН**Эдийн засгийн ухааны
доктор (Ph.D.), профессор**Д.ГАН-ОЧИР**Эдийн засгийн ухааны
доктор (Ph.D.)

ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙГ БИЙ БОЛГОХ БОДЛОГЫН АСУУДАЛД

Эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангаж чадсанаар хүний хөгжил, эдийн засгийн хөгжлийн суурь орчныг бүрдүүлж, ядуурлын түвшин буурдаг билээ.

Манай орны хувьд эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох нь НҮБ-аас дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, орлогын түвшний ангиллыг дээшлүүлэх, Монгол иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг олгоно. Гэхдээ Монголын эдийн засгийн өсөлт нь хэлбэлзэл өндөртэй, богино давтамжтай буюу өрнөл-уналтын мөчлөг 3-4 жил тутам тохиолдож байна.

ДНБ-ий жилийн дундаж өсөлт 1991-2016 онд 4.4 хувь байлаа. Энэхүү дундаж түвшний өсөлт нь ядуурал буурах, дундаж орлоготой орнуудын эгнээнд орох, хүний хөгжлийн индекс өсөх суурь нөхцөл болсон юм. Гэхдээ эдийн засгийн өсөлт нь экспортын эрдэс бүтээгдэхүүний үнийн мөчлөг, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын урсгал зэрэг гадаад цочролоос гадна эдийн засгийн дотоодын бодлогоос ихээхэн хамаарч байна.

Манай орны хөгжлийн стратеги нь уул уурхайн салбараас орж ирэх орлогод суурилсан уул уурхайн бус, өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох явдал юм. Үүний тулд энэ чиглэлээр хийгдсэн эмпирик судалгаа, бусад орны туршлагыг сайтар судалж, өөрийн орны онцлогт тохирсон тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.


Эдийн засгийн өсөлтийн шинж чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

Улс орнуудын түүхэн хөгжлөөс харахад, эдийн засгийн өсөлтийн бага хэмжээний ялгаа нь амьжиргааны түвшний маш том ялгааг бий болгож, тус ялгаа цаашид хадгалагдахад хүрчээ. Гэхдээ эдийн засгийн өсөлт нь

тогтворгүй, хэлбэлзэл өндөртэй болохыг олон тооны судалгаа харуулж байна. Улс орнууд хоорондын эдийн засгийн өсөлт ялгаатай байхаас гадна нэг орны хувьд ч цаг хугацааны туршид ихээхэн өөрчлөгддөг эмпирик баримт байна. Ялангуяа хөгжиж буй орнуудад энэ байдал илүү тод ажиглагддаг ажээ (Printchett 2000).

Эдийн засгийн өсөлтийн динамикийг сайтар ойлгохын тулд түүнд нөлөөлөх хүчин зүйлс, бодлогын нөлөөг авч үзэх ёстой. Rodrick (2003) өсөлтийн эдийн засгийн онолыг системтэй тайлбарлахын тулд өсөлтийн “барагцаалсан тодорхойлогч” болон “гүнзгий тодорхойлогч”-ийг хооронд нь ялгах шаардлагатай гэж үзсэн. Эдгээр тодорхойлогч хүчин зүйлсийг Зураг 1-т харуулав.

Зураг 1. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс



Гэхдээ энэхүү задаргааг тайлбарлахдаа болгоомжтой хандах ёстой. Учир нь биет болон хүмүүн капиталын хуримтал, бүтээмжийн өсөлт нь эндоген буюу өөр бусад хүчин зүйлсээр давхар тодорхойлогддог учраас өсөлтийн эх үүсвэрийн тэгшитгэлд бүтцийн тайлбар өгөх боломжийг хязгаарладаг. Жишээ нь, өсөлтийн 80 хувь нь биет болон хүмүүн капиталын хуримтлалаар, үлдсэн хэсэг нь бүтээмжийн өсөлтөөр тайлбарлагдана гэдэг нь технологийн өөрчлөлт байгаагүй бол өсөлтийн 80 хувь нь бий болох байсан гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, технологийн өөрчлөлт байхгүй бол хуримтлуулах сэдэл маш бага байж, капиталын гүнгийрэлт тэр

хэмжээгээр буурна. Түүнчлэн эдийн засгийн өсөлт нь дээрх тэгшитгэлд ороогүй бусад суурь хүчин зүйлсээс хамаарахын зэрэгцээ өсөлт нь өөрөө хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлж болно. Иймд эдгээр хуримтлал, бүтээмжийн өсөлт нь эдийн засгийн өсөлтийн хамгийн сайн барагцаалсан тодорхойлогч хүчин зүйл юм.

Эдийн засгийн өсөлт, хөгжилд чиглэсэн бодлогын жорын түүхэн хувьсал

1960-1970 он: Өсөлтөд чиглэсэн 1960-1970 оны бодлого нь төрийн оролцоог чухалчилж байлаа. Тухайлбал, гадаад валют, хөрөнгө оруулалтын сангийн дутагдлыг зээл, тусламжаар нөхөх (Chenery болон Watanabe 1958, хоёр зөрүүний загвар), эдийн засгийн хөгжилд хүрэхийн тулд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийх (Rosenstein-Rodan 1943, том түлхэлтийн загвар), эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт л хөрөнгө оруулалт хийх (Hirschmann 1969) зэрэгт буурай хөгжилтэй орны засгийн газар анхаарах шаардлагатай хэмээн зөвлөж байлаа. Хөгжлийн эдийн засгийн онолын үүднээс буурай хөгжилтэй орны хувьд “бага орлого—> бага хуримтлал—>бага хөрөнгө оруулалт—>бага орлого” гэсэн “чөтгөрийн тойрог”-оос гарахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэсэн үзэл тухайн үед ноёрхож байсан ажээ.

1980-1990 он: Хөгжиж буй ихэнх орнуудын эдийн засгийн өсөлт 1980-аад онд доогуур түвшинд байсан юм. Газрын тосны хямралын дараа Латин Америкийн ихэнх орнууд өрийн хямралд ороод байхад Азийн бар орнууд амжилттай хөгжиж байлаа. Их Британийн Тэтчер, АНУ-ын Рейганы мандан бадралын үе тухайн цаг үед мөн тохиож байсан билээ. Тухайн үеийн улс төрийн дээрх удирдагчдын баримталж байсан эдийн засгийн өсөлтийн үзэл баримтлал нь зах зээлийг хөгжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, чөлөөт худалдаа хийх зэрэгт төвлөрч байлаа. Энэхүү өсөлтийн талаарх шинэ үзэл баримтлал нь Вашингтоны зөвшилцөл (Washington consensus)-д тусгалаа олжээ. Вашингтоны зөвшилцлийн анхны санаа нь засгийн газрын хэт оролцоо нь саад учруулдаг тул түүний үйл ажиллагааг аль болох боломжит бага түвшинд хязгаарлахад оршиж байжээ (Spence 2011). Латин Америкийн орнуудад 1980-аад онд хэрэгжсэн шинэчлэл болон өрийн хямралыг шийдвэрлэх арга зам нь энэхүү зөвшилцөлд суурилсан байна.

1990-2000 он: Гэвч 1990-ээд оноос олон улс оронд хүлээгдэж байснаас эсрэг үр дүн гарч, эдийн засгийн нөхцөл байдал мууджээ. Хөгжиж буй орнуудын нэг хүнд ногдох орлогын медиан өсөлт 1960-1979 онд 2.5 хувь байсан бол 1980-1998 онд 0 хувь болсон юм. Тэг

өсөлттэй байсан энэ хугацааг алдагдсан 20 жил гэж нэрлэдэг ажээ (Easterly 2001). Улс орнуудын түүхэн туршлагад суурилан үзэл баримтлалын жагсаалтыг шинэчлэх, нэмэх шаардлага тулгарчээ. Тухайлбал, хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийх, үр ашгийг дахин хуваарилах зэргийг эн тэргүүнд нэмж оруулсан боловч энэхүү шинэ хандлагын хувьд эдийн засгийн өсөлтөд засгийн газар маш чухал үүрэг (хувийн секторыг дэмжих, тэдний оролцоо орхигдсон)-тэй гэж үзэж байлаа. Улмаар Вашингтоны зөвшилцлийн жор нь эргэлзээ дагуулж эхэлсэн. Тухайн орны бэрхшээл нь уламжлалт салбарт хэт төвлөрч, бусад салбарт шинэ санаа, технологийн дэвшил гарч ирэхгүйд оршиж байлаа. Эдийн засаг нь хэт долларжсан тул ханш нь өрсөлдөх чадварыг дэмжих хэрэгсэл болж чадаагүй.

Иймд илүү үр дүнтэй аж үйлдвэржилтийн бодлого (Засгийн газрын гажуудал /авилга/-ыг хамгийн бага байхаар зах зээлийн гажуудлыг засварлах)-ыг мөн адил чухалчлах болсон юм (Hausman болон Rodrick 2005). Вашингтоны зөвшилцөл 1990-2000 онд шүүмжлэлд өртөн, дэмжлэг хүлээхээ больж, Дэлхийн банкны ерөнхийлөгч Wolfensohn “Вашингтоны зөвшилцөл нас нөхчөөд олон жил болсон” гэж 2004 онд мэдэгдсэнээр судлаач, бодлого боловсруулагчид 2000 оны эхнээс шинэ зөвшилцлийн эрэлд гарлаа. Шинэ зөвшилцөлд нэр дэвшигчдийн жагсаалтыг дараах байдлаар багцалж болно:

- Шинэ Вашингтоны зөвшилцөл (Kuczynski болон Williamson 2003);
- Сайжруулсан Вашингтоны зөвшилцөл (Rodrik 2006);
- Барселоны зөвшилцөл (Blanchard et al. 2004);
- Бээжингийн зөвшилцөл (Joshua 2004);
- Бээжин-Сөүл-Токиогийн зөвшилцөл (Lee and Matthews 2011);
- Дэлхийн банкны өсөлт, хөгжлийн хорооны зөвшилцөл (CGD 2008).

Цаашид анхаарах асуудлууд болон “Улаанбаатарын Зөвшилцөл”-ийг санал болгох нь

Эдийн засгийн өсөлтөд шаардлагатай зайлшгүй болон хүрэлцээтэй нөхцлийг тодорхойлж чадах эдийн засагчдын итгэл алдарсаар байна. Түүхэн цаг хугацаанд Вашингтоны зөвшилцөл няцаагдаж байсан хэдий ч цаг хугацааны турш илүү боловсронгуй болж, өргөжсөөр өнөөдрийг хүрлээ. Гэхдээ улс орон бүрийн хөгжлийн стратегид нийцэх бодлогын жорын жагсаалт гаргахад хүндрэлтэй байдаг. Ялангуяа, хөгжлийн сайн стратеги боловсруулахын тулд тухайн орны эдийн засаг, улс төрийн талаарх мэдлэг шаардлагатай билээ.

Монгол улсын хувьд эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгохын тулд өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх явдал туйлын чухал байна. Энэ том сорилтыг амжилттай даван туулахын тулд харилцан нийцтэй макро эдийн засгийн болон бүтцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд мэдлэг, боловсролтой иргэд, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хүчтэй институцийг бүрдүүлэх нь чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Байгалийн арвин их баялгаас ирэх өгөөжийг боломжит өндөр түвшинд байлгах аар эдийн засгийн эргэлтэнд оруулснаар үндэсний хуримтлал бий болдог. Энэхүү хуримтлалыг цаашид урт хугацааны өсөлтийг бий болгох хүмүүн капитал, дэд бүтэц, шинэ технологи, аж үйлдвэржилт, бүс нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт болгон зарцуулах боломж байна. Төрийн хөрөнгө оруулалт нь хувийн салбарын хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, илүү их хөрөнгө оруулалтыг даллах зарчмыг баримтлах нь зүйтэй. Хувийн хөрөнгө оруулалтын өсөлтөд макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ. Хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дан ганц санхүүжилтээс гадна зах зээл, эдийн засаг үр ашигтай ажиллах механизмыг бүрдүүлсэн зохицуулалт (өрсөлдөөнийг дэмжих, хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй болгох, өрсөлдөх чадварыг хангах валютын ханштай байх, хүн бүр боломжоос тэгш хүртэх, байгаль орчноо хамгаалах зэрэг) туйлын чухал юм. Уламжлалт салбар болох хөдөө аж ахуй, уул уурхай, тэдгээрийн түүхий эдийг боловсруулах салбарыг хөгжүүлэх хүрээнд орон нутгийн хөгжилд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Хот, хөдөөгийн ялгаа нэмэгдэх нь боломжийг тэгш хүртэх ялгааг улам гүнзгийрүүлж, цаашид бүтээмж, орлогын ялгааг үлэмж нэмэгдүүлэхэд хүргэнэ.

Мөн засаглал, институц бол онцгой анхаарах тулгамдсан асуудал болоод байна. Хүчтэй, сайн институц нь байгалийн баялгийн хараалаас зайлсхийж, тогтвортой өсөлтийг хангах боломжийг олгох бөгөөд үүнийг бүрдүүлэх нь авлигаас ангид, хуулийг ёсчлон хэрэгжүүлдэг, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрддөг төрийн байгууллага, албан хаагчдаас эхэлнэ. “Олуулаа хэлэлцвэл буруугүй ...” гэдэг зүйр үгийг санаж, сайн

бодлогыг тааруу бодлогоос ялгахын тулд бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулж, ухаан бодлоо уралдуулж хэвших нь бодлогын томъёолол, түүний хэрэгжилт бодитой, үр дүнтэй байхад туслах учиртай.

Олон улсын туршлага, өмнөх цуврал судалгаа (Н.Баяртсайхан 2017, Д.Ган-Очир 2017a,b), өөрийн орны онцлог байдалд тулгуурлан Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх “Улаанбаатарын зөвшилцөл” (Ulaanbaatar Consensus)-ийг бид дараах байдлаар санал болгож байна:

- Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх,
- Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах,
- Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, тууштай нэмэгдүүлэх, бодит эдийн засаг, инфляцийг тогтворжуулах,
- Эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх,
- Хүчтэй санхүүгийн салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох,
- Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай локоматив хэдэн компанийг бий болгож дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх
- Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрүүдэд багтаж орох, газар нутгийн байршлын давуу талаа ашиглах, аймаг, орон нутгууд тэгш хөгжих боломж бүрдүүлэх,
- Байгалийн баялагаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, “Баялгийн ерөөл”-д хүргэх, хүртээмжтэй өсөлтийг бий болгох.


Энэхүү зөвшилцөл нь улс төрийн орчноос үл хамааран Монгол төрийн хөгжлийн бодлогод тусч, хэрэгжиж байх учиртай. Иймд эрдэмтэн, судлаачид, бодлого боловсруулагч Таны санаа, бодол туйлын чухал байна.

Улаанбаатар хотын инфляци 1 дүгээр сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2018 оны 1 дүгээр сард** улсын хэмжээнд **6.9%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **8.0%-д** хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн



УЛААНБААТАРЫН ЗӨВШИ

Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг хангахын тулд дэлхийн улс орнууд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, бодлогын зорилт, тунхаглалыг “бодлогын зөвшилцөл” болгон гаргадаг жишиг бий. Үүний нэг хэлбэр болох “Улаанбаатарын зөвшилцөл” чуулганыг Монголбанкнаас санаачлан, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, бодлогын тууштай, нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн 8 зарчмыг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлж, оролцогчдын байр суурийг нэмж тусгаснаар эдийн засгийн бодлогын шийдвэрийн суурь зарчим болгон тунхаглахаар зорьж байна.



ОУВС-ийн суурин төлөөлөгч

Нейл Сакер: Монгол шиг уул уурхайн экспортод тулгуурласан бодлогын зарчим ямар байх вэ гэвэл гол нь төсвийн бодлого зохистой, зөв байх ёстой. Тодруулбал, Засгийн газар боломжтой бүх орлогын эх үүсвэрийг дайчлан цуглуулаад, зохистой хөрөнгө оруулалтад зориулах хэрэгтэй. Монгол Улсын хувьд дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэлээд шаардлагатай байдаг. Түүнээс гадна хүний хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалтад анхаарах хэрэгтэй. Төсвийн бодлогыг баримтлан хэрэгжүүлэхдээ алдагдлыг их байхаас сэрэмжилснээр өр их хэмжээгээр нэмэгдэхээс зайлсхийж чадна. Дараагийн нэг бодлого нь мэдээж мөнгөний бодлого. Тэгэхээр мөнгөний бодлогын хүүгийн түвшин эдийн засгийг дэмжих хэмжээнд байх ёстой. Түүнчлэн валютын ханшийн уян хатан дэглэмийг баримтлах нь чухал. Ингэснээр гаднаас орж ирж байгаа аливаа цочролыг уян хатан ханшаар зөөлрүүлж өгдөг.



Эдийн засагч С.Дэмбэрэл:

Хөгжилд хүргэх бодлогын зөвшилцлийн талаар олон улсын шинжээчдийн хэлсэн үг, саналууд бий. Тэгэхээр хөгжлийн жорууд гарч болно. Хамгийн гол нь яаж хийх вэ гэдэгтээ байгаа. Арга зүйн хувьд шийдвэр гаргалтын мод гэдэг зүйлийг санал болгодог. Найман зарчмаа жагсааж бичээд, нэг бүрчлэн эрэлт болон нийлүүлэлтийн аль алинд нь анхаарах юу байна вэ гэдгийг задлан шинжлээд, үүнийхээ үндсэн дээр шийдвэр гаргалтын модоо гаргаж болно. Өөрөөр хэлбэл, тэргүүлэх чиглэл тухайн улсад хэтэрхий их байвал тэр нь тэргүүлэх чиглэл биш болчихдог. Тиймээс тэргүүлэх чиглэлээ маш зөв, тодорхой гаргах ёстой. Магадгүй найман зарчим маань 4 болж болно. Гэхдээ дотроо маш их задардаг, шийдвэр гаргалтын модтой. Мод нь эрэлт, нийлүүлэлтийн талын аль алиных нь асуудлыг шийдэх гаргалгаануудтай байх ёстой юм. “Улаанбаатарын зөвшилцөл” цаашаа ингэж л явна.

“НӨХЦӨЛ” – ӨӨР хэн юу хэлэв?



Азийн Хөгжлийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч Л.Амар:

Манайх шиг уул уурхайн баялгийн орлогоос хамааралтай эдийн засагт хамгийн чухал, эдийн засгийн “Үндсэн хууль” гэж хэлж болохоор хууль нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Баялгийн сан буюу Ирээдүйн өв сангийн тухай хууль шүү дээ. Энэ хоёр хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллах нь чухал байна. Хэдийгээр 2010 онд төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан ч түүнээс хойш бараг жил бүр хуулиа өөрчилж ирсэн. Анх тогтоосон хязгаарлалтуудаа өөрчилсөн. Өрийн тааз, төсвийн алдагдлын хязгаар гэх зэргийг өөрчилсөн. Мөн өрөнд юуг оруулж тооцох вэ гэдэг тодорхойлолтуудаа хүртэл олон удаа өөрчилсөн. Тэгэхээр бид байгалийн баялгаас орж ирж байгаа орлогыг яаж урт хугацаанд үр ашигтай, бодлогоор авч явах вэ гэдэг дээрээ зөвшилцөлд хүрээгүй байна гэсэн үг. Тогтвортой хөгжлийн бодлогод хүрэх суурь нь тэр хууль гэдгийг намууд, улс төрчид ойлгоод, нэгдсэн зөвшилцөл, ойлголцолд хүрэх нь чухал юм.



Эдийн засагч Ж.Дэлгэрсайхан:

Бид эдийн засаг олон жил дараалан өслөө гэж ярьдаг ч нийт иргэдийн амьжиргаа, амьдралын чанар төдийлөн сайжирдаггүй. Энэ агуулгаар нь харвал бид энэхүү зөвшилцлийг үнэхээр дээд түвшинд хүлээн зөвшөөрүүлж, эрх зүйн чадамжтай, олон талын оролцоотой гаргуулж чадвал аль нэгэн улс төрийн хүчний нөлөөлөлтэй эдийн засгийн шийдвэрүүд гарах магадлал нь багасна. Ингэснээрээ эдийн засаг урт удаан хугацаанд тогтвортой хөгжих боломж бүрдэнэ. Эдийн засаг урт хугацаанд тогтвортой өссөнөөр иргэдийн амьжиргаа, амьдралын чанар дээшлэх нөхцөлийг бий болгох юм. Өнөөдөр манай улсын эдийн засаг хэсэг зуур огцом өсөөд, тэр нь эргээд хямралын нөлөөгөөр арилаад байгаа учраас иргэдийн амьжиргаа сайжирч чадахгүй байна. Бид эдийн засгийнхаа бүтцийг төрөлжүүлж, институцээ сайжруулж чадаагүй байна. Дээрээс нь тогтвортой бодлого, төлөвлөгөө алга. Тогтвортой бодлого, төлөвлөлтийг бий болгоход энэ зөвшилцөл үр дүнгээ өгөх болов уу.



Эдийн засагч Н.Дашзэвэг:

Эдийн засгийн өсөлтийн талаар ярьж байгаа бол Монгол Улс ойрын 5, 10, 20 жилд бүтээмжээ яаж дээшлүүлэх вэ гэдэг асуудлыг ярих ёстой. Энгийнээр хэлбэл, Монгол Улсад 1 сая 200 мянган хүн ажиллаж байгаагаас аж үйлдвэрийн салбарт 200 орчим мянган нь л ажиллаж байна. Үлдсэн нэг сая нь үндсэндээ худалдаа, үйлчилгээний салбар буюу нэмүү өртөг бүтээхэд бараг оролцдоггүй салбарт ажиллаж байгаа юм. Тэгэхээр бид 300 мянган малчдаа 150 мянга болгоод, 400 мянган үйлчилгээний ажилчдаа 200 мянга болгочоод, бусад нь экспортын чиглэлийн, валют олдог үйлдвэрт ажиллах юм бол манай эдийн засгийн бүтээмж сайжирч, цалин дээшилнэ. Тиймээс бүтээмж бий болгоход суурь зарчим чиглэгдэх ёстой байна.



ХХБ-ны Гүйцэтгэх захирал

О.Орхон: Сүүлийн үеийн зөвшилцөл, онолуудад инновацийн тухай тусгах болсон. Тэгэхээр инновацийг дэмжих асуудлыг тусгах хэрэгтэй байна. Түүнчлэн ядуурлыг бууруулах, орлогын тэгш бус байдлыг багасгах, байгаль орчин нийгмийн асуудалд анхаарах гэсэн санаануудыг тусгах нь зүйтэй гэж бодож байна. Эдгээр нь зөвшилцлөөс гаргаж байгаа найман зарчимд ерөнхий тусгагдсан байна. Улам тодорхой болгоё. Өнөөдөр бидний хөгжилд гол гацаа болж байгаа зүйл юу вэ гэвэл бид өнөөдөр онолгүй явж байна. Онол байлаа гээд ч бид концепцгүй байна. Концепцгүй байна гэдэг нь бодлого байхгүй. Бодлого байхгүй учраас систем байхгүй, систем байхгүй учраас төлөвлөлт байхгүй. Төлөвлөлт байхгүй учраас манлайлал байхгүй. Манлайлал байхгүй бол үүнийг хийх хүн манай улсад байхгүй гэсэн үг. Тэгэхээр Монгол Улсын ирэх 20, 30, 50 жилийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн концепци зайлшгүй байх хэрэгтэй.



Ерөнхий сайдын ахлах зөвлөх

Н.Энхбаяр: Төрийн бодлогод хэлэлцүүлэг, мэтгэлцээний чанарыг дээшлүүлэх, “Тинк Танк”-уудыг хөгжүүлэх шаардлага бий. Дэлхийн банкнаас ч манайд ингэж зөвлөсөн. Аливаа асуудлыг улс төрийн өнцгөөр биш, мэргэжлийн нүдээр хардаг, бодлогын шийдвэр гарахаас өмнө мэргэжлийн зөвлөгөө өгдөг “Тинк Танк”-уудыг бэхжүүлэх хэрэгтэй гэсэн үг. Хоёрдугаарт, мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёр маш хүчтэй. Гэхдээ энэ хоёр асуудал бүгдийг шийдэж чадахгүй байгаа нь аль ч улсын пратктикт харагддаг. Тийм учраас мөнгөний бодлого, төсвийн бодлогоос гадна санхүүгийн зах зээлийн бодлого, бүтцийн өөрчлөлтийн бодлогоо хамт уялдуулж ижил түвшинд хөгжүүлэх зүйтэй юм. Гуравдугаарт. Урт хугацааны прогнозын чадвараа сайжруулах хэрэгтэй. Манай улсын хувьд эдийн засгийн бүтэц нь уул уурхай, хөдөө аж ахуйд суурилсан. Тийм учраас энэ хоёр салбарынхаа эрсдэлийг тодорхой хугацааны өмнө зөв прогноз хийж чаддаг болчихвол

том ололт болно. Тэгэхгүйгээр өчигдөр мэдээгүй байсан, өнөөдөр гэнэт үнэ уначихлаа гэдэг зүйл ярьж болохгүй. Дэлхий нийт бараг газар хөдлөлтөөс бусад бүх зүйлийг урьдчилан харж чаддаг болсон. Цаг агаараас эхлээд зах зээл, түүхий эдийн үнэ, яаж өөрчлөгдөх гэх зэрэг. Манай улс 10-аадхан төрлийн түүхий эд экспортолж байгаа. Ихэнх нь үнийн савалгаа багатай. Тэгэхээр таамаглах боломжтой л гэсэн үг. Дээр нь цаг агаарын хувьд сарын хугацаатайгаар мэдээлдэг. Энэ бол зүгээр иргэдэд чиглэсэн мэдээлэл. Үүнийг дор хаяж, 3-6 сар болгож, харж чаддаг байх хэрэгтэй. Мөн зөвхөн монгол орныхоо цаг агаар бус бүс нутгийн хэмжээгээр судалж, хардаг байх хэрэгтэй. Тэгж байж бид Монгол Улсад юу болох гээд байна вэ гэдгийг урьдчилан харж чадна.

МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

“Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд зааснаар”
өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах
чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний бодлогыг
боловсруулж, хэрэгжүүлнэ.



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн
мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10
дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн
барина.



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах




Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх,
хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр
эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах
ажлыг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг
Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын
хүсэлтээр өөр дээрээ байршуулж, гүйлгээг хийнэ.



Засгийн газрын хүсэлтээр Засгийн газрын үнэт
цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна.



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл
ажиллагаа эрхэлнэ.



Банк болон хуульд тугайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх
зорилгоор банк байгуулах зөвшөөрөл банкинд олгоно.



Үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм,
журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл
ажиллагаанд хяналт тавина.

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкн дахь
тухайн банкны харилцах дансаар дамжуулан
гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний
төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад
валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн
гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангана.



Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй
адилгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж
авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг
хэрэглэгчийг хамгаалах хяналттай хослуулна.



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11
зарчмыг нэвтрүүлнэ.



Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг
дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.




Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк,
санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан
сэргийлэх зорилгоор тус бодлогыг боловсруулна.



Макро зохистой бодлогыг заавал байлгах нөөц зэрэг
хэрэгслүүдээс ашиглан хэрэгжүүлнэ.



БОДИТ МЭДЭЭЛЭЛ ЗАХЫН ОРОЛЦОГЧДАД ШУУРХАЙ ХҮРСНЭЭР ХАНШ БОДИТОЙ ТОГТОХ БОЛОМЖ НЭМЭГДЭНЭ

“Монголбанкны мэдээлэл” товхимол уншигч танаа 2018 оны эхний дугаараасаа эхлэн төв банкны өдөр тутмын үйл ажиллагаатай танилцах “Монголбанк юу хийдэг вэ” буланг хүргэж эхэлсэн. Энэ удаад Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн хэлтсийн Санхүүгийн зах зээлийн хэлтсийн эдийн засагч Ц.Сувдын нэг өдрийн ажлыг сурвалжиллаа. Тэрээр санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой ажлуудыг голчлон хариуцаж ажилладаг юм.

◆ Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар, тэр дундаа Санхүүгийн зах зээлийн хэлтсийн үйл ажиллагааны гол онцлогийн талаар ярилцлагаа эхэлье?

-Миний ажиллаж буй Санхүүгийн зах зээлийн хэлтэс нь товчхондоо Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг, мөнгөний захын бүхий л үйл ажиллагааг хариуцдаг. Төв банкны байнгын санхүүжилтийн хэрэгслүүд, гадаад валютын дуудлага худалдаа, нээлттэй захын үйл ажиллагаа зэргийг зохион байгуулж, дотоодын валютын болон төгрөгийн мөнгөний захтай ойрхон ажилладаг. Ерөнхийдөө манай хэлтсийнхэн зах зээлийн талаар мэдээллийг түргэн авч, ашиглах шаардлагатай хурдан темптэй орчинд ажилладаг гэж хэлж болно.

Миний хувьд мөнгөний бодлогын хэрэгжилтэнд чухал нөлөөтэй мөнгөний захын дэд бүтцийг сайжруулахтай холбоотой ажлыг голчлон хариуцан ажилладаг. Зөв зохистой ажилладаг дэд бүтэцтэй байх нь мөнгөний бодлогын хэрэгжилтэнд цаашлаад мөнгөний зах, санхүүгийн захын хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг.

◆ Санхүүгийн захын дэд бүтэц гэж яг юуг хэлэх вэ. Дэд бүтцийг хөгжүүлэхэд Монголбанк хэрхэн анхаарч ажилладаг вэ?

-Ямар ч эдийн засгийн бүтэцтэй улс оронд тогтвортой өсөлтийг бий болгоход санхүүгийн зах чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс зөв зохистой, саадгүй ажилладаг санхүүгийн захын дэд бүтэц зайлшгүй шаардлагатай. Санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг нь онцолж, холбогдох олон улсын байгууллагаас санхүүгийн захын дэд бүтцийн үндсэн 12 зарчмыг тодорхойлж, хэрэгжүүлдэгийг онцлох нь зүйтэй гэж бодож байна.

Дэд бүтэц гэдэгт тухайн зах үр ашигтай, найдвартай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүрэг бүхий арилжаа, төлбөр тооцооны систем, энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллага зэрэг орох бөгөөд үүнд програм хангамж, хууль

эрх зүйн орчин зэрэг хамааралтай болж ирдэг.

Монголбанкнаас сүүлийн жилүүдэд захын дэд бүтэц, төлбөр тооцооны системийг сайжруулах ажилд нэлээд их анхаарал хандуулж байгаа нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, захын үр ашгийг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа. Тухайлбал, өнгөрсөн онд банк хоорондын валют арилжааны цахим талбарыг шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр банк хоорондын валютын арилжаа өмнөхөөс мэдэгдэхүйц нэмэгдэж, хэд хэдэн давуу талууд бий болсон.

◆ Банк хоорондын валют арилжааны цахим талбарыг анх яаж нэвтрүүлсэн бэ?

-Ер нь валют арилжааны цахим талбар, валютын бирж байгуулах асуудал олон жилийн өмнөөс яригдаж байсан юм байна лээ. Хувийн хэвшлээс ч хийж нэвтрүүлэх сонирхлоо илэрхийлж байсан. Гэхдээ ийм төрлийн үйл ажиллагаа нь захад оролцогчдын нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал учраас эхний ээлжинд Монголбанкнаас нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлд валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээг авахаар тусгаж, Монголбанкнаас холбогдох бэлтгэл ажлыг зохион байгуулж, 2017 оны 4 дүгээр сард банк хоорондын валют арилжааны цахим талбарын үйл ажиллагааг эхлүүлсэн. Бид бэлтгэл ажлын хүрээнд бусад орны туршлагыг судалж, зах зээлд оролцогчдоос судалгаа авч, арилжааны мэргэжилтний ёс зүйн дүрмийг боловсруулсан.

◆ Арилжааны мэргэжилтний ёс зүйн дүрэм гэдгийг тодруулахгүй юу?


-Хэдийгээр санхүүгийн зах зээлд оролцох, арилжаа хийхтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалтууд байдаг боловч эдгээр үйл ажиллагаа нь оролцогч хоорондын итгэлцэл дээр суурилдаг. Иймд энэ итгэлцлийг нэмэгдүүлэх, хадгалахын тулд ёс зүйн дүрэм чухал үүрэгтэй. Ялангуяа, арилжааны хэлцэл хийхийн өмнө нөгөө талын оролцогчийг урьдчилан мэдэх боломжгүйгээр цахим орчинд арилжаа хийж байгаа үед оролцогч хоорондын

итгэлцэл зайлшгүй чухалд тавигдана. Иймд бид CFA институтын Code of ethics and Standards of professional conduct болон ACI холбооны The Model code-ийг судалж, арилжааны мэргэжилтний ёс зүйн дүрмийг боловсруулсан бөгөөд банк хоорондын валют арилжааны цахим талбарын үйл ажиллагааг эхлүүлэхтэй хамт тус дүрмийг Монголын банкны холбооноос баталсан.

◆ **Валют арилжааны цахим талбарыг нэвтрүүлснээр голлох ямар давуу тал бий болсон бэ. Үр дүнгийн хувьд хэрхэн тодорхойлох вэ?**

-Тус арилжааны талбар нь банкууд нэг цахим орчинд төвлөрөн хоорондоо валют арилжаа хийдэг биет бус арилжааны талбар юм. Тус цахим талбарт арилжааны санал оруулах, хэлцэл хийх, төлбөр тооцоо хийх бүх үйл явц цахимаар хийгдэх тул мэдээж үйл ажиллагааны эрсдэл буурч, цаг хугацаа хэмнэх боломжтой болсон. Арилжааны цахим талбар бий болсноор валютын зах зээлд оролцогчдад захын эрэлт нийлүүлэлт, ханшийн талаар бодитой мэдээллийг түргэн, нээлттэй "харагддаг" болсон. Мөн Монголбанк арилжааны төлбөр тооцоог зохион байгуулж, төлбөр тооцоотой холбоотой эрсдэлүүдийг тодорхой хэмжээнд бууруулсан. Өмнө нь банк хооронд валютын арилжаа хийх дэд бүтэц хөгжөөгүй байсантай холбоотойгоор банкууд хоорондоо валютын арилжаа төдийлөн идэвхтэй хийдэггүй байсан. Харин цахим талбарыг нэвтрүүлснээс хойш банк хоорондын валют арилжааны идэвх 2 дахин өссөн бөгөөд 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 316 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний ам.доллар болон юанийн арилжаа цахим талбарт хийгдээд байна.

Банкуудын цахим талбарт хийсэн ам.долларын арилжаа



◆ **Цахим талбар нээгдсэнээр оролцогчдод бодит мэдээлэл, түргэн шуурхай хүрэх боломжтой болсон гэдгийг дурдлаа. Үүний ач холбогдол нь юу вэ?**

-Бодит мэдээлэл оролцогчдод түргэн шуурхай хүрэх нь манайх шиг улирлын хэлбэлзэл өндөр эдийн засагтай орны хувьд их чухал гэж бодож байна. Үүний ач холбогдлыг тайлбарлахын тулд ханш яаж тогтдог тухай эхлээд ярья. Валютын ханш нь бусад бараа бүтээгдэхүүний адил эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээс шалтгаалан тогтдог. Энэ эрэлт, нийлүүлэлтэд гадаад төлбөр тооцооны бодит хэрэгцээнээс гадна ханшийн талаар

спекулятив шинжтэй хүлээлт нөлөөлдөг. Спекулятив шинжтэй хүлээлтэд бодит валютын урсгал, улс орнуудын макро эдийн засгийн орчин нөлөөлөхөөс гадна арилжаа хийж буй тухайн хүний зан чанар, сэтгэл санааны хүчин зүйлс хүртэл нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, валютын ханш нь эдгээр үзүүлэлтүүд, валютын захад оролцогчдын хүлээлтийг өөртөө шингээсэн мэдээлэл гэж хэлж болно. Дашрамд дурдахад ханш, үнэ ойр ойрхон огцом хэлбэлздэг зах дээр спекулятив шинжтэй арилжаа их явагддаг. Гэхдээ ямар ч санхүүгийн хэрэгслийн хувьд спекулятив арилжаа тодорхой хэмжээнд байх нь тухайн бүтээгдэхүүний хөрвөх чадварыг нэмэгдүүлж, үнэ уян хатан тогтох бололцоог бий болгодог. Хамгийн гол нь энэ бүхэн бодит мэдээлэл дээр суурилсан байх ёстой. Энэ утгаараа банк хоорондын валют арилжааны цахим талбар нь арилжаа найдвартай, үр ашигтай хийгдэх бололцоогоор хангахаас гадна бодит мэдээллийг оролцогчдад шуурхай хүргэж, ханш бодитой тогтоход эерэг нөлөө үзүүлж байгаа ач холбогдолтой юм.

◆ **Монголбанкнаас валют арилжааны цахим талбарыг нэвтрүүлэхдээ бусад улс орны туршлагыг ч бас судалсан байх. Тэгэхээр дэлхийн бусад улс орны валютын захын хөгжил, цахим платформыг хөгжүүлсэн туршлага ямар байдаг юм бол?**

-Мэдээж улс орон бүр өөрсдийн эдийн засгийн бүтэц, валютын захын хөгжил, захынхаа багтаамжтай нийцсэн дэд бүтцийг бий болгох нь оновчтой байх. Тухайлбал, Солонгос улсад ийм төрлийн валют арилжааны цахим талбарын үйлчилгээ үзүүлдэг ялгаатай 10 орчим брокерийн компаниуд байдаг. Захад оролцогчид нь өөрсдөд илүү давуу талыг бий болгож өгсөн цахим талбараар үйлчлүүлдэг байх жишээтэй. Ерөнхийдөө хатуу валют буюу чөлөөтэй хөрвөдөг валюттай орнуудад валютын арилжаа нь ихэвчлэн төвлөрсөн бус хэлбэрээр хийгдэж, төрийн оролцоо бараг шаардлагагүй байдаг. Харин эсрэгээрээ валютын ханш хэлбэлзэх дарамт бий болдог орнууд, ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад валютын урсгалыг удирдах, банк хоорондын захыг хөгжүүлэх зорилгоор Төв банкны оролцоотойгоор банк хоорондын валют арилжааны цахим талбарыг хөгжүүлсэн туршлага байдаг юм байна лээ.

◆ **Эцэст нь өөрийнхөө яаж ажилладаг, одоо яг юун дээр ажиллаж байгаа талаар дурдахгүй юу?**

-Би ихэвчлэн хийх ажлын жагсаалтаа календар дээр гаргаж, тухайн ажилд хэр их цаг зарцуулахаас хамааран ажлаа зохион байгуулдаг. Мэдээж яаралтай цаг үеийн даалгавруудыг тухайн үед нь хийж гүйцэтгэнэ. Ерөнхийдөө, өдөр тутмын шинж чанартай ажлуудаа түрүүлж хийгээд дараа нь судалгаа шинжилгээний ажлуудаа хийдэг. Би сүүлийн үед цахим талбарын арилжааг улам идэвхжүүлэх, програм хангамжийг дотооддоо хөгжүүлэх боломжийн талаар судлах, мөн үүнтэй холбоотой бусад улсын туршлагыг судлах зэрэгт анхааран ажиллаж байна.

◆ **Ярилцсанд баярлалаа.**



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНК

1925 оны 04-р сарын 01-нд Монголын худалдаа аж үйлдвэрийн банкны 4-р хэлтэс нэртэй ЗХУ-ын иргэн Жуковский даргатай 8 орон тоотой ажиллаж эхэлсэн

1954 он БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр Улсын банкны харъяа Завхан аймаг дахь хэлтэс болон өргөжсөн.

1960 он Тосонцэнгэл хотод салбар хэлтэс, 1963 онд Завханмандал суманд анхны тооцооны касс ажиллуулсан.

1972 он Завхан аймгийн төвд оройн касс нээгдэж 22 цаг хүртэл ажилладаг болов.

1979 он Улсын банкны Завхан банкны контор өргөжиж бүх сумдад тооцооны төв, Тосонцэнгэл хотод хэлтэс бүхий бүтэц бий болсон.

1991 он банк хувийн аж ахуйтанд зээл олгох, ажилтан албан хаагчдын цалин олгох, худалдааны цэг салбаруудаас бэлэн мөнгийг хураах, мөнгөн гүйлгээ эмиссийн бодлогыг зохион байгуулж, хадгаламж хуримтлуулах, УААА-н салбаруудын хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжинд урт, эргэлтийн хөрөнгөд богино хугацаат зээл олгох зэрэг бүхий л үйлчилгээг нэг банк төвлөрүүлэн гүйцэтгэж байв.



Зүүн гар талаас хянан шалгагч Ц.Энхбат, салбарын захирал Я.Наранцэцэг, нягтлан бодогч Р.Эрдэнэ-Ундрах арын эгнээ хянан шалгагч Д.Бат-Ундраа, нярав Д.Ренчинмядаг, жолооч Б.Болдбаатар

Улиастай сумын харъяат Банзрагчийн Оросоо гуай өдгөө 78 настай. Улсын банкны Завхан аймаг дахь хэлтэст байцаагч мэргэжилтнээр ажиллаж байжээ. Тэрээр энэ тухайгаа дурсан ярьсныг энд онцлон үлдээхийн учир нь тус аймаг дахь банкны салбарын амьд түүх болж байгаад юм.

Б.Оросоо: Би СЭЗТ-ийн банкны ангийн анхны төгсөгч бөгөөд 1961 онд 21 настайдаа УБЕХ-ны томилолтоор Завхан аймгийн банкинд ажиллахаар ирж байсан

юм. Тэр үед хэлтсийн даргаар нь Дашбалжир, ерөнхий ня-боор нь Даш, нярваар Зинамидар зэрэг хүмүүс ажиллаж байлаа. Тэдгээрээс Зинамидар гуайг банкинд хамгийн олон жил ажилласан мөн ямар ч зөрүү, буруу гаргаж байгаагүй, 1 мөнгөний ч хариултыг заавал өгдөг зарчимч хүн байсныг дурдахад таатай байна. Тухайн үед банкны хэлтэс нь Тосонцэнгэлд салбар хэлтэс, Завханмандалд тооцооны салбартай бусад суманд ямар ч банкны нэгжгүй сумын мөнгийг шуудангийн машинаар явж хураадаг байлаа шүү дээ. Банкны хэлтэст дээрхи албан тушаалтнуудаас гадна дансны ня-бо 3, мөнгө хураагч 4, галч, цэвэрлэгч тус бүр 1 ажиллаж байсан. Банк нь үдээс өмнө ажиллаж, үдээс хойш 3 цаг гэхэд гүйлгээгээ хааж касс, мемориалын баримтаа үдэж, даргадаа хянуулахаар өгдөг байв. Түүний өгүүлсэн энэхүү багаха дурсамж нь 1960-аад оны банкны түүхэн дүр зураг юм.

Завхан аймаг дахь Монголбанкны салбар нь 1991-07-01-нд байгуулагджээ. Анхны захирлаар Б.Сандагсүрэн, ерөнхий ня-бо Ч.Цогбадрах, эдийн засагч Ц.Гомбоо, Я.Наранцэцэг, оператор ня-бо Д.Нямсүрэн, С.Сувдмаа, ахлах нярав Б.Цэрэндулам, жолооч С.Мөнхбат, мөнгө хураагч Б.Тэрбиш, мөнгөний



Улсын банкны Завхан аймаг дахь конторын хамт олон 1984 он.

Банкууд 2017 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаар нийт 135 061,4 сая төгрөгийн актив хөрөнгөтэй, 11 259,0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, байгууллага, иргэдийн нэр дээр 128 183,0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй үүнээс 1 184,0 сая төгрөгийн зээл, хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалд бүртгэлтэй байна.

Иргэдээс 56 369,5 сая төгрөгийн хугацаатай хадгаламж, 15 056,2 сая төгрөгийн хугацаагүй хадгаламж татсан байна. Банкуудад нийт 120 135 харилцагч, 26 911 зээлдэгч, 64 466 хадгаламж эзэмшигч, 7245 тэтгэвэр тэтгэмж авагч байна.

хянагч П.Дэнсмаа, мөнгө тоологч Бямбасүрэн, Н.Цэцэгмаа нар ажиллаж, 1991 оны 09-р сар хүртэл аймгийн төсөвт газрууд Асгат, Тэс суманд тооцооны касс, худалдааны цэгүүдээс мөнгө хураах ажиллагааг эрхэлж байв.


Монгол Улсад 2 шатлалтай банкны систем үүсч Завхан аймагт 1991 оны 03-р сард ХАА-н банк, 08-р сард ХОТШ банк, 09-р сард Монгол Даатгал банк, Улсын банкнаас өрх тусгаарлан арилжааны үйл ажиллагаа явуулах болсноор Монголбанкны чиг үүрэг өөрчлөгдөж төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэх, эмиссийн бодлогыг барьж банкуудыг бэлэн мөнгөөр хангах, гүйлгээнээс мөнгө татах, мөнгөний аюулгүй байдлыг хангах, банкуудын үйл ажиллагаанд хяналт тавих, харилцагч хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй ажилладаг болов.

1992 оноос Монголбанкны салбар арилжааны үйл ажиллагаанаас

бүрэн чөлөөлөгдөж хуулийн дагуу банкуудад хяналт тавих, банк хоорондын клирингийн тооцоог хийж, банкуудыг зээлжүүлэх, бэлэн мөнгөөр хангах төрийн мөнгөний бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Одоо Завхан аймагт ХААН, ХАС, Капитал, Төрийн банкны 53 салбар, тооцооны төвд 25 сум, суурин газар, нийт 287 ажилтан ажиллаж, харилцагч байгууллага, иргэдэд банк санхүүгийн үйлчилгээ үйлчилж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 21/II ӨДРИЙН БАЙДЛААР)



ECONOMICS

2011 ОНЫ НОБЕЛИЙН ШАГНАЛ-ТОМАС САРЖЕНТ, КРИСТОФЕР СИМС НАРЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ШАЛТГААН, ҮР ДАГАВАРЫН ТАЛААР ХИЙСЭН ЭМПИРИК СУДАЛГАА



“Монголбанкны Мэдээлэл” товхимолд эдийн засгийн салбарт хийгдсэн томоохон нээлтүүдийг тайлбарлан таниулах зорилгоор Нобелийн шагналтнуудын буланг нээсэн билээ. Нобелийн нэрэмжит шагналыг анх 1901 онд 5 чиглэлд олгож эхэлсэн бөгөөд түүнээс хойш 67 жилийн дараа 1968 оноос Шведийн төв банкны санаачлага болон хандиваар эдийн засгийн шинжлэх ухаан нэмэгдэж, салбартаа чухал нээлт хийсэн эрдэмтэн судлаач нарыг жил болгон шалгаруулж, шагнал гардуулдаг болсон. Энэ дугаарт бид 2011 онд эдийн засгийн салбар дахь Нобелийн шагналыг хүртсэн эрдэмтэд болох Томас Саржент, Кристоцер Симс нарыг танилцуулж тэдний судалгааны ажлыг энгийн үг хэллэгтэйгээр хүргэхийг зорилгоо.

“Макро эдийн засаг дахь шалтгаан, үр дагаврын эмпирик судалгаа”-нд хийсэн нөр их хөдөлмөр, хувь нэмрийнхээ төлөө Томас Саржент ба Кристофер Симс нар 2011 онд эдийн засгийн салбар дахь нобелийн шагналыг хүртсэн. Эмпирик судалгаа гэдэг нь юмс үзэгдлийг танин мэдэх сонгодог аргуудын нэг бөгөөд ажиглалт дээр суурилдаг юм. Тэд докторын зэргээ нэг цаг хугацаанд буюу 1968 онд Харвардын их сургуульд хамгаалжээ.

Макро эдийн засгийн бодлого,

тухайлбал төсөв, мөнгөний бодлогыг эрх бүхий байгууллагууд ирээдүйд эдийн засаг, хувийн секторт хэрхэн нөлөөлөхийг тооцоолон тодорхойлж байж өөрчлөх эсэхийг шийддэг. Харин нөгөө талаас айл өрх, бизнес эрхлэгчид зэрэг эдийн засгийн оролцогчид бодлогын хандлагыг ажиглаж, цаашдын төлөв байдлын талаарх өөрсдийн төсөөлөл дээр үндэслэж хөрөнгө оруулалт, хуримтлал, ажил эрхлэлт зэрэг чухал шийдвэрүүдээ гаргадаг байна. Өөрөөр хэлбэл бодлого эдийн засагт нөлөөлдөг боловч, эдийн засаг нь мөн бодлогыг тодорхойлдог хоёр талт уялдаатай болохыг эдгээр хоёр эрдэмтэд судалгааны ажилдаа онцолж, хүлээлтийн үр нөлөөний ач холбогдлыг тайлбарлажээ.

Хоёр талт уялдааны бодит жишээ бол олон улсад 1970-аад оны үед газрын тосны үнээс хамааралтайгаар инфляци огцом өссөн ч, бүтээмж муу байсан учраас улс орнууд инфляцийг онилж бууруулах бодлого баримталж эхэлсэн. Энд инфляцийн өсөлт нь бодлогын шинэчлэлийн шалтгаан болсон уу, эсвэл бодлого нь инфляци буюу эдийн засгийн гол үзүүлэлтийн өөрчлөлтийг нөхцөлдүүлсэн үү

гэдгийг тухайлан хэлэхэд ярвигтай боловч тодорхой ажиглалтын аргыг ашиглаж тодорхойлох боломжтой.

Хүний зан төлөв, шийдвэр гаргах хэв маяг гэдэг бол маш их ээдрээтэй зүйл бөгөөд түүнийг тоон мэдээлэл дээр үндэслэж, системийн хэмжээнд харж, хүлээлтийг таамаглах, улмаар бодлогын шийдвэр гаргах нь макро эдийн засгийн түлхүүр асуудлуудын нэг байсаар ирсэн. Харин тэрхүү хүлээлт гэдэг ойлголтыг эмпирик судалгааны арга зүй буюу ажиглалт дээр үндэслэж судлах аргыг Саржент болон Симс нар боловсруулж чадсан. Тэдний боловсруулсан аргууд нь нэг зүйлийг зорьдог ч, харьцангуй ялгаатай. Саржент инфляцийн зорилтыг өөрчлөх урт хугацааны бодлогын өөрчлөлт нь эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг судлах аргын суурийг бий болгосон бол Симс бодлогын хүү өөрчлөгдөх, эсвэл шокын шинжтэй эдийн засагт богино хугацаанд үр нөлөө үзүүлэх судалгааны арга зүйг боловсруулжээ.

Саржент: Бодлогын өөрчлөлт - системийн үр нөлөө

Дайны дараах он жилүүдэд улс орнууд эдийн засгийн өсөлтийг

урьтал болгон инфляция хөөрөгдөөд эцэс сүүлд нь эргээд үнийн өсөлтөө тогтворжуулахад анхаарч ирснийг Нью-Йоркийн их сургуулийн Томас Саржент анхаарч судалсан байна. Төв банк бодлогын хүүгээ өсгөх, эсвэл инфляцийн зорилтот түвшинг өөрчлөх зэрэг системийн хэмжээний бодлогын өөрчлөлт хийх үед эдийн засагт ямар эргэшгүй үр нөлөө үүсгэдгийг бүтцийн макро эконометрикийн аргачлал дээр үндэслэж шинжилжээ. 1970-аад оны үед тэрбээр хэд хэдэн шинжлэх ухааны нийтлэлийг тус аргачлалыг хэрхэн бий болгох, тооцоолох, асуудал шийдвэрлэх сэдвийн хүрээнд бичсэн байна. Бүтцийн макро эдийн засгийн судалгааны арга зүй нь эдийн засгийн бодлогын өөрчлөлт болон айл өрх, бизнесийн хүлээлт хоёрын урт хугацааны хамаарлыг судлахад ашиглагддаг.

Томас Саржентын судалгааны арга зүй нь гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэг нь макро эдийн засгийн бүтцийн тоон загварыг бий болгох. Хоёрдугаар хэсэг нь бий болгосон загварыг задлан шинжилж, хүлээлт зэрэг параметрт эдийн засгийн ямар хувьсагчид нөлөөлж болохыг тодорхойлж, тайлбарлах. Эцсийн хэсэгт статистикийг ашиглах бөгөөд цаг хугацааны тоон мэдээллийг загварт оруулснаар эмпирик судалгааг хийж үр дүнг гаргаж авах. Түүний боловсруулсан гурван хэсэг бүхий арга зүй нь маш их хэмжээний дата-мэдээлэл дээр хэрхэн эмпирик буюу ажиглалтын судалгааг хийж болох боломжтойг харуулсан.

Кристофер Симс: Макро эдийн засгийн шокиг тодорхойлж, шинжлэх нь

Кристофер Симс нь 1970-аад он ба түүнээс өмнөх хугацаанд Төв банкууд, Засгийн газар, цаашлаад

судлаач нарын ашигладаг байсан макро эдийн засгийн нүсэр загваруудыг шүүмжилдэг байснаараа Томас Сарженттай адил. Тиймээс ч Симс макро эдийн засгийн тоон үзүүлэлтийг судлах шинэ аргачлалыг боловсруулсан. Симсийн аргачлалын ач холбогдол нь макро эдийн засгийн түүхэн үзүүлэлтүүд дэх шокиг таних, тэрхүү шокиг хэрхэн бусад макро хувьсагчдад нөлөөлдөг болохыг судлахад оршиж байгаа.

Кристофер Симс Вашингтонд 1942 онд төрсөн. Дунд сургуульд сурч ахуйд нь тооны багш нь чухал нөлөө үзүүлсэн ба Харвардын их сургуульд ЗХУ-ын математикч Хинчиний мэдээллийн кодчиллын онолыг дэлгэрүүлэн судалж бакалаврын зэрэг хүртжээ. Инженерүүд түүний судалгааны ажил цахилгааны инженерийн онолд хувь нэмрээ оруулах ёстой гэж ухуулж байсан ч, тэрбээр мэдээллийн онолыг эдийн засгийн шинжлэх ухаанд илүү тусгалаа олно гэж үзсэн. Тиймээс ч докторын зэргээ хамгаалахаар Берклигийн их сургуульд орж микро эдийн засгийн онол, эконометрик, мөнгөний эдийн засгийн онолыг судалж байгаад 2 дахь жилээсээ Харвардын их сургуульд шилжиж судалгааны ажлаа дуусгасан байна.

Симсийн арга зүй макро эдийн засгийн бодлогын шийдвэр гаргалтад түгээмэл ашиглагддаг бөгөөд мөн л 3 үе шатад хуваагддаг. Эхний шатанд вектор-авторегрессийн буюу VAR загварыг ашиглаж макро хувьсагчийн цаашдын таамаглалыг бий болгоно. Дараагийн шатанд эдийн засагт нөлөөлөх суурь шокуудыг ялгаж авна. Эцэст нь суурь шокууд макро хувьсагчдад хэрхэн нөлөөлж байгааг судалж, импульс-хариу үйлдлийн шинжилгээг хийнэ.

Эдийн засагт шок гэдэг нь газрын тосны үнэ өсөх, өрхийн хэрэглээ урьдчилж тооцоолж байснаас зөрж, огцом буурах, бодлогын хүү бизнес эрхлэгчдийн хүлээлтээс зөрж өөрчлөгдөх зэрэг эдийн засгийн гэнэтийн үзэгдлүүдийг хэлдэг. Шокиг түүхэн дата, үзүүлэлтүүд дээр үндэслэж таамаглахад бэрхшээлтэй. Симсийн бий болгосон судалгааны арга зүй энэ чиглэлд хувь нэмэр оруулж, бэрхшээлийг давах боломжийг олгосон.

Макро эдийн засгийн эмпирик судалгаа өнөө цагт


Томас Саржент болон Кристофер Симс нар харилцан хамааралгүй ажиллаж байсан ч тэдний 1970-аас 1980-аад оны үед хийж гүйцэтгэсэн бүтээлүүд нэг нь нөгөөгөө нөхсөн шинжтэй байсан. Тэдний бий болгосон судалгааны арга зүйнүүд нь өнөөдөр эдийн засгийн эмпирик судалгаанд томоохон талбарыг бий болгож чадсан. Улмаар макро эдийн засгийн бодлого боловсруулж, хүлээлтийг тодорхойлоход эдийн засгийн түүхэн тоон үзүүлэлтүүдийг ашиглах боломжийг бүрдүүлсэн юм.

Саржент, Симс нарын санал болгосон аргуудыг өнөөгийн эдийн засагчид, Төв банкууд өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал, инфляцийн хүлээлтийн судалгаа, инфляцийн төлөв байдлын тайлан зэрэг эдийн засгийн төлөв байдал, хүлээлтийг магадлахад ашиглагддаг. Симс нь VAR загварын эцэг гэж нэрлэгддэг бөгөөд тус загвар нь өнөө цагт эдийн засгийн судалгаа шинжилгээнд түгээмэл ашиглагддаг. Харин Саржент нь бүтцийн эдийн засгийн эцэг ба түүний арга зүй мөнгөний бодлогыг боловсруулахад ашиглагдсаар байна.

Тоймлосон: Н.Батжин

1939 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

1939 оны мөнгөн тэмдэгт нь 1, 3, 5, 10, 25, 50, 100-н төгрөгийн дэвсгэртэй. Энэ үеэс эхлэн мөнгөн тэмдэгт дээр “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” гэж улсын нэрийг албан ёсоор бичих болсон байна. 1939 оны цаасан мөнгөн дэвсгэрт бүгд адил бичвэртэй, мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнэ, өнгөөрөө ялгагдана. Серийн дугаар нь нэг үсэг, зургаан оронтой тоотой. Мөнгөн тэмдэгтийг ЗХУ-д үйлдвэрлэсэн бөгөөд 1966 онд албан ёсоор гүйлгээнээс хассан боловч хэрэг дээрээ 1955 оноос гүйлгээнээс гарчээ.



Нүүр тал: “Бүгд Найрамдах Монгол Ард Улс”, түүний дор “Монголын худалдаа аж үйлдвэрийн банк” гэж монгол бичгээр, нэрлэсэн үнийг зурхайн тоогоор бичсэн. Баруун талд нь жанжин Д.Сүхбаатарын хөрөг, зүүн талд нь соёмбо дүрсэлсэн. Мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнийг монгол бичиг, зурхайн тоо, араб тоогоор хоёр талын хүрээнд сөөлжүүлэн бичиж, серийн дугаарыг доод хэсэгт хар, улаан өнгөөр даржээ.

Ар тал: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хоёрин есдүгээр он”, түүн дор

1. Энэхүү мөнгөн тэмдэгт цаас нь банкинд буй үнэ бүхий металл, гадаад валютууд ба монгол банкинд барьцаалагдсан бараануудаар барьцаалагдмуй.
2. Банкны тэмдэгт цаасыг аливаа зүйлд өгч авалцваас зохимуй.
3. Энэхүү тэмдэгт цаасыг дууриалган хуурамчаар үйлдвэрлэвээс хууль ёсоор шүүмүй.” гэж монгол бичгээр бичжээ. Уг бичвэрийн хоёр талд өлзий хээн дээр нэрлэсэн үнийг зурхайн тоо, монгол бичгээр, дөрвөн буланд зурхайн тоо болон араб тоогоор сөөлжүүлэн бичсэн.



Ганибалын АМАРТҮВШИН

Г.Амартүвшин нь 2014 оны 7 сараас ХасБанкны Ерөнхий Захирлаар томилогдон ажиллаж байна. ХасБанкинд ажиллахын өмнө Г.Амартүвшин нь Тэнгэр санхүүгийн нэгдлийн ерөнхий захирлаар 3 жил ажилласан.

Тэрээр Казахстан улсын арилжааны томоохон банк болох Казкоммерц банкны эрсдлийн удирдлагын газрын дарга, ерөнхий захирлын алба хашиж төслийн санхүүжилт болон зээлийн санхүүжилтийн чиглэлээр арваад жил ажилласан туршлагатай.

Казкоммерц банкинд ажиллахын өмнө Г.Амартүвшин нь ABN AMRO Банкны Лондон, Амстердам болон Чикаго хотуудын салбарт ажиллаж байв. ABN AMRO банкны бүтцийн зээлийн хэлтэст ажиллаж байхдаа Европын газрын тос, шатдаг хий, эрчим хүч, харилцаа холбоо гэх мэтчилэн хэд хэдэн өндөр хэмжээний гүйлгээг хариуцан ажиллаж байжээ. Г.Амартүвшин нь хөдөлмөрийн гараагаа ABN AMRO дахь бэлэн мөнгөний менежментийн газраас эхэлсэн бөгөөд улмаар тэндээ Ерөнхий эрсдэлийн удирдлагын хэлтэст шилжин оржээ.

Тэрээр Бельги улсын Брюссель хотын Европын Их сургуулийн бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй бөгөөд АНУ-ын Бостон хотын Харвардын бизнесийн сургуулийн, бизнесийн удирдлагын магистрын дипломыг гардан авсан билээ.

Г.АМАРТҮВШИН: ХАНШИЙН САВАЛГАА БАГАСЧ, ЗЭЭЛИЙН ХҮҮ БУУРАХ БОЛОВ ҮҮ ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

ХасБанкны Ерөнхий захирал Г.Амартүвшинтэй ярилцлаа

► Юуны өмнө банкны салбарын ойрын сонин сайхнаас хуваалцана уу?

-Ойрын сонин гэвэл банкуудад активын чанарын иж бүрэн үнэлгээ хийгдээд дууслаа. Банкны системийн хэмжээнд том сорилт байсан гэж би хувьдаа дүгнэж байна. ХасБанкны хувьд дотоод эрсдэлийн удирдлага, зээлийн хэлбэртээ зарим өөрчлөлтүүд оруулж, сайжруулсан юм нэлээд бий. Нөгөө талаас онолын хувьд ч гэсэн жишээлбэл, барьцаа хөрөнгийн үнэлгээн дээр хөндлөнгийн үнэлгээний компаниудаар барьцаа хөрөнгөө үнэлүүлэхэд, бидний мөрдөж ирсэн аргачлал маань зөв байсан гэдэг нь батлагдсан. Энэ утгаараа бидний хувьд харьцангуй давуу талтай байлаа. Шалгалтын урьдчилсан дүгнэлтээс банкны салбар нэлээд тогтвортой байр суурьтай байгаа нь харагдсан. ХасБанкны хувьд ч сорилтыг амжилттай давж, сайн дүн сонссондоо баяртай байгаа. Энэ жил бид үйл ажиллагаагаа нэлээн өргөтгөж, чамгүй өсөлт хийх төлөвлөгөөтэй байна. Эдийн

засгийн байдал ч сайжирч, өнгөрсөн оны хоёрдугаар хагасаас тэлж эхэлсэн. Энэ хандлага энэ жил ч бас үргэлжлэх төлөвтэй байна. Тийм учраас иргэд, бизнесүүдийг дэмжих санхүүжилтээ хангалттай гаргана гэж харж байна.

► Саяын үнэлгээ хэр цаг үеэ олсон гэж бодож байна вэ. Активын чанарын үнэлгээг хийж эхлэх үед банкууд нэлээд эсэргүүцэж байна гэх мэдээлэл гарч байсан. Ер нь үнэлгээг хийх явцад ойлголцохгүй асуудал гарч байсан уу?

-Миний мэдэхээр ийм цар хүрээтэй, том шалгалт Монголын банкны системд өмнө нь байгаагүй. Тийм болохоор банкууд бүгдээрээ сандарсан. Манай банк ч бас ялгаагүй яах билээ, бэлэн үү, үгүй юу гээд тэвдсэн л дээ. Гэхдээ эцсийн дүндээ бичиг, цаасны ажлуудаа нэлээд чамбай сайн бэлтгэж, шалгалтыг амжилттай даван туулсан. Цаг үеэ олсон уу гэвэл мэдээж олсон гэж үзэж байна. Манай эдийн засаг өсөлт, уналтын циклтай явдаг. Энэ нь ч банкны үйл ажиллагаанд шууд

нөлөөлж, системийн хэмжээнд тусгалаа олж байдаг. Эдийн засгийн байдлаа дагаад хямрах төлөвтэй болчихсон үед банкуудад шалгалт орох шаардлага зүй ёсоор байсан. Шинээр нэвтрүүлсэн ажлуудаа зөв болохыг үнэлүүлж, цаашид улам илүү итгэлтэйгээр хөгжих урам аваад байна.

► Активын чанарын үнэлгээтэй холбоотойгоор банкуудын дүрмийн санг нэмэгдүүлж, 100 тэрбум төгрөгт хүргэхээр болсон. Энэ шалгуурыг банкууд хэр амжилттай давах бол?

-Томоохон 5-6 банк асуудалгүй байх. Бусад банкуудын хувьд яг хэлж мэдэхгүй байна. Манай банкны хувьд олон улсын томоохон санхүүгийн байгууллагууд хувь эзэмшигчээр байдаг учраас цагаа тулаад, хөрөнгө босгоход хүрвэл ямар ч асуудалгүй гэж бодож байна. Гэхдээ бидний хувьд одоогийн төлөвлөснөөр бол тэр шалгуурыг хангахад шинээр хөрөнгө татах шаардлагагүй гэж харагдаж байгаа.

► Монголбанк санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аяныг санаачлан банкуудтай хамтран хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн эрх зөрчигдөхөөс танай банк жишээлбэл хэрхэн сэргийлж байна вэ?

-ХасБанк дан ганц ашгийн хойноос хөөцөлддөггүй, харилцагчид үр өгөөжтэй байх, тэдний цаашид өсөн дэвжих боломжийг бий болгохыг зорьж ажилладаг. Ийм учраас олон улсад мөрддөг "Харилцагчийг хамгаалах ухаалаг зарчим"-уудыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Ил тод, нээлттэй байх, харилцагчийн гомдлыг шийдвэрлэх зэрэг эдгээр зарчмууд дотор зээлдэгчийг өрийн дарамтаас хамгаалах зарчим байдаг. Өөрөөр хэлбэл харилцагчид төлж чадахаас нь их зээл олгохгүй байх, зээлийн эргэн төлөлт нь хамгийн ихдээ өрхийн орлогын 60%-аас хэтрэхгүй байх гэх мэт зохицуулалтууд байдаг. Түүнчлэн хэт өндөр хүү, шимтгэл шаардах арга барилаас хол явах зарчмууд байдаг. ХасБанк энэ бүгдийг аль болох баримтлаад явж байгаа. Ер нь бол Монголбанкны бодлогын хүү буурч байна. Эдийн засаг тогтворжоод, ханшийн савалгаа буураад эхлэхээр хүүгийн хүлээлт ч бас буурч байна. Бид 2018-2019 онд хүү буурах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Энэ нь зээлдэгчийн хувьд эерэг өөрчлөлт болно гэж бодож байна. Сая хямралын үед айл өрх, аж ахуйн нэгжүүд хямралд орсон шинж тэмдэг нэлээд ажиглагдсан. Зээлийн багцыг харахад ч гэсэн хүндрэлтэй, нөхцөл байдал тодорхой хэмжээнд үүсч байсан. Цаашдаа энэ нөхцөл байдал сайжирна гэж харж байна.

► Та "Шарк Танк" нэвтрүүлэгт хөрөнгө оруулагчаар оролцож, санхүүгийн харилцаанд орж байгаа иргэдтэй тулж харьцаж

байгаа шүү дээ. Эндээс харж байхад бизнес эрхлэхээр зорьж байгаа иргэдэд ажиглагдаж байгаа нийтлэг дутагдлын талаар энд хэрхэн дүгнэх вэ?

-Санхүүгийн мэдлэг дутмаг байгааг олон хүн харсан байх. Наад зах нь компанийн үнэлгээ, санхүүгийн төлөвлөгөөг яаж хийх вэ, ашиг орлогоо яаж тооцох вэ гэх зэрэг дээр их сул байдаг юм билээ. Үүн дээр банкууд ч бас тодорхой хариуцлага хүлээгээд, олон нийтэд сургалт хийх, мэдлэг мэдээлэл олгох ажлыг зохион байгуулах ёстой. Монголбанк ч бас энэ ажлыг маш сайн хийж байгаа. Бүгдээрээ л сэтгэлээ гаргаж ажиллахгүй бол, зээлдэгч нар "надад барьцаа хөрөнгө байгаа учраас зээл авчихна" гэсэн буруу ойлголттой байна. Барьцаа хөрөнгө чухал. Гэхдээ нэн чухал нь биш. Хамгийн чухал нь мөнгөн урсгал. Бизнес хангалттай орлого олоод, зардлаа нөхөөд, зээлээ төлөх мөнгөн урсгалтай байна уу гэдэг чинь барьцаанаас илүү найдвартай тогтвортой байдлын баталгаа. Банкууд барьцаа хөрөнгөөр зээлийг төлүүлнэ гэсэн бодлоготойгоор зээл олгохгүй шүү дээ. Бизнес дээр мөн адил. Компания үнэлэхдээ зүгээр л нэг мөрөөдлийн тоо ярьдаг. Тэр нь өнөөдрийн бизнесийнх нь байж байгаа байдал, ирээдүйн төлөв байдалтай нь ямар ч холбоо байхгүй. Магадгүй гарааны бизнес байж болно. Тэглээ гээд бодит санхүүгийн төлөвлөгөө хийж сурах хэрэгтэй. Тэгж байж, хөрөнгө оруулагчид сонирхолтой санал тавина шүү дээ.

► Яг үүнтэй холбоотойгоор тухайлбал, ХасБанкны хувьд толон нийтэд чиглэсэн тодорхой ажил хийх төлөвлөгөө байна уу?

-ХасБанк энэ чиглэлд тодорхой ажлууд хийж байгаа. Жишээлбэл, бид жижиг дунд бизнес эрхлэгчид

болон харилцагчдынхаа уулзалтыг тогтмол зохион байгуулж, тэдэнд эдийн засгийн нөхцөл байдал, бизнесийн орчны эрсдэлийн талаар танилцуулж, зөвлөгөө өгөхийн дээр, санхүүжилт татах боломжуудын талаар мэдээлэл өгч байна. Мөн эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн үйлчилгээг ашигласнаар үйлдвэрлэлийн зардлаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэх, цаашилбал байгаль орчинд хувь нэмрээ оруулах ач холбогдлын талаар иргэд бизнесүүдэд сурталчлан таниулж, дэмжин ажиллаж байна. Цаашид энэ үйл ажиллагаагаа улам өргөжүүлэх болно. Би хувиараа ч хамаагүй заавал манай банкны харилцагч гэхгүйгээр бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх боломжтой. Надаас зөвлөгөө авъя гэж хүмүүс их ханддаг л даа. Тэр болгонтой уулзаад байж чадахгүй учраас ганц нэг удаагийн нэгдсэн уулзалтыг зохион байгуулах бодолтой байгаа.

► Банкинд зээл хомс байгаа тухай яригддаг. Бас зээлийн хүү өндөр байна гэдэг. Үүнийг та хэрхэн тайлбарлах вэ?

-Олон шалтгаан байгаа ч зээл хүсэж байгаа хүний өөрийнх нь зээлээ төлөх чадвар, магадлал муу байдаг л гол асуудал байна гэж боддог. Зээлийн түүх муу, эсвэл өмнө нь зээл авч байгаагүй, эсвэл зээлийн графикт төлбөрийг нь ашиг орлоготой нь харьцуулахад бодит бус харагдах зүйл олон харагддаг. Мөн барьцаа хөрөнгөний асуудал гэх мэтчилэн. Гэхдээ барьцаа хөрөнгийн тал дээр хоёр, гурван хөтөлбөр байгаа шүү дээ. Зээлийн батлан даалтын сан гэх мэтчилэн. Тэгэхээр зээлийн хүртээмж аажмаар тэлж байгаа л гэж хэлэх байна.

► Актив удирдлагын компани байгуулах тухай ярьж эхэлсэн. Гэвч төр банкуудын чанаргүй

зээлийг хариуцах нь зохистой эсэх дээр маргаан үүсэж эхэлж байгаад намжлаа. Энэ асуудлаар хууль гаргахаар зорьж байгаа шүү дээ. Ийм хууль байх хэрэгцээ шаардлагын тухай та ямар бодолтой явдаг вэ?

-Бусад орнуудын жишгийг харвал Хятадад нэлээд амжилттай хэрэгжсэн байдаг. Актив удирдлагын компани нь төрийн өмчит том банкуудаасаа чанаргүй зээлийг нь нэлээд сайн, үнэ тохирч худалдан авч чадсан. Тэр үеэр эдийн засаг нь ч өссөн болохоор алдагдалгүй ажиллаж чадсан байдаг. Шведэд бас сайн туршлага бий. Үүнээс бусдаар бусад оронд амжилттай хэрэгжсэн түүх ховор юм билээ. Миний ойлгосноор эрсдэлтэй зээл гэдэг чинь алдагдал хүлээсэн зээл гэсэн үг. Тэр алдагдлыг нэг тал нь хэт их давамгайлж үүрэхгүйгээр хувааж үүрвэл амжилттай болох магадлалтай. Өөрөөр хэлбэл, хувийн актив удирдлагын компани эсвэл төрийн өмчийн дэмжлэгтэй ч байна уу, хамаагүй. Тэр нь муудсан зээлийг худалдаж авахдаа зах зээлийн үнээр нь бус эргэж төлөгдөх магадлалтай дүнгээр нь худалдаж авах хэрэгтэй. 100 төгрөгийн зээл муудсан байлаа гэхэд 60-70 төгрөг нь төлөгдөх магадлалтай гэж үзээд, тэр дүнгээр нь худалдаж авбал, илүү ашигтай. Банк нь 20-30 төгрөгийн алдагдал хүлээнэ гэсэн үг. Иймэрхүү байдлаар ажиллавал илүү үр дүнтэй болох байх.

► Тэгвэл, хөрөнгийн үнэлгээний асуудал чухлаар яригдаж байгаа. Хөрөнгийн үнэлгээг яаж хийвэл зохимжтой байдаг вэ?

-Олон улсын стандартыг аль болох хурдан нэвтрүүлэх хэрэгтэй. Манайх өөрийн онцлогтой явна гээд өөр стандартаар явбал, өөрсдийгөө хуурч байна л гэсэн үг. Сая активын чанарын үнэлгээний

өмнө манай үнэлгээний компаниуд олон улсын стандартад хараахан хүрээгүй гэдэг нь тодорхой байсан. Гэхдээ үнэлгээний явцад тэдгээр компаниуд өөрсдийн стандартаа нэлээд сайжруулсан юм шиг байна лээ. Мэдээж хөрөнгийн үнэлгээ гэдэг нь төрлөөсөө хамаараад өөр. Дэлхийд мөрдөгдөж байгаа стандартад гурван янзын л аргачлал байгаа. Түүгээр л явах ёстой.

► Одоо БАЗЕЛ2 стандарт руу зорьж байна. Үүнд банкууд маань бэлэн байна уу?

-ХасБанкны жишгээр аваад үзэхэд Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт хөгжлийн банк гэх зэрэг том хөрөнгө оруулагчтай. Тэд биднээс маш өндөр стандартыг шаарддаг. Дээр нь бид гаднаас синдикат зээл, худалдааны санхүүжилт зэргийг босгоход бас л өндөр стандарт шаарддаг. Тэгэхээр бид хүссэн хүсээгүй барууны стандартыг дагахаас өөр аргагүй болж байгаа. Тиймээс үүнийг хүлээн зөвшөөрөөд, олон улсын стандарт руу шилжихдээ бэлтгэх нь л чухал юм.

► Монголд хөрөнгийн зах зээл төдийлөн хөгжөөгүй нэг шалтгааныг банк хэт давамгайлсан гэж шүүмжлэх нь бий.

-Энэ бол манай эдийн засгийн бүтэцтэй холбоотой. Манайх шиг хөгжиж байгаа эдийн засгийн хувьд эхлээд банкууд нь давамгайлдаг. Яах аргагүй хамгийн их капитал буюу хөрөнгийг бодит эдийн засаг руу дамжуулж өгдөг хэрэгсэл нь болдог. Яг энэ үед дундаж хүү өндөр, ханш савалгаатай байдаг. Яваандаа тодорхой хэмжээгээр хүү буураад, ханшийн савалгаа багасаад эхлэхээр хүү буурч ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ өсч, компанийн үнэлгээ нэмэгдэнэ. Илүү бодит үнэлгээтэй компаниуд гарч ирэх магадлал нь өндөр болонгуут

аажим аажмаар хөрөнгийн бирж, хувьцаа, бонд руу хөрөнгө оруулалт хийх хүсэл эрмэлзэл нь бий болно. Өмнө нь 17-18 хувиар хадгаламжаа хийж байсан хүмүүс хүү 12 болоод эхлэхээр эрсдэлтэй ч гэсэн 20-25 хувийн өгөөжтэй хөрөнгийн зах зээл рүү хөрөнгө оруулах сонирхол нь нэмэгдэнэ. Тэгэхээр капитал шифтинг буюу банкууд дахь хөрөнгө хөрөнгийн зах руу шилжих үзэгдэл бий болно. Үүнийг дагаад аажмаар банкны эзлэх хувь багасч, хөрөнгийн зах зээлд өрсөлдөөн нэмэгдэнэ.

► ХасБанкны хувьд жижиг, дунд бизнесийг дэмжихэд их анхаардаг. Монгол шиг улсын хувьд шинээр эхэлж буй "старт ап" бизнест хөрөнгө босгох боломж хязгаарлагдмал байдаг. Үүнийг шийдэх арга юу байх бол?

-Хязгаарлагдмал гэхээр нэг талаасаа тийм. Нөгөө талаас зүгээр л хүмүүстэй уулзаад явж байхад, "Танай бизнест чинь хөрөнгө оруулъя, хамтаръя" гэх хүн олон л тааралддаг. Тэгэхээр амжилттай бизнес гэж юуг хэлэх вэ гэвэл өсдөг бизнесийг хэлнэ. Зүгээр нэг гоё санааг хөл дээр нь босгоод, өсөлтгүй явж байвал тэр амжилттай бизнес биш. Эхний ээлжинд хөл дээрээ тогтсон бол цаашдаа яаж илүү томрох вэ, яаж зах зээлээ тэлэх вэ гэдэг нь чухал. Тэр компани өсөн дэвшиж байж, илүү өгөөжтэй байж хөрөнгө оруулагчид сонирхоно. "Старт ап" компаниудын хувьд нэгдүгээрт, "миний бодож байгаа бизнес үнэхээр ашигтай юу, үгүй юу" гэдэг асуудал. Хүний мөрөөдөж байгаа зүйл тэр болгон ашигтай биш байж болно шүү дээ. Хоёрдугаарт, санхүү тал дээр. Энэ бараагаа ийм өртгөөр гаргаад, ийм үнээр зараад, ингэж ашиг олоод, цаашдаа хөрөнгө оруулалтаа ингэж нөхнө гэх зэрэг төлөвлөгөө нь маш тодорхой байх ёстой.

► Та **“Улаанбаатарын зөвшилцөл” хэлэлцүүлэгт орсон. Эдийн засагчдын зүгээс банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх тухай саналууд тавигдсан. Та ямар саналтай байна вэ?**

-Хэлэлцүүлгийн хувьд зөв алхам байсан гэж бодож байна. Банкны өрсөлдөх чадварыг сайжруулах талаар бол том, жижиг гэхээсээ илүү засаглал чухал. Зөв үйлдлийг Монголбанк дэмжиж, буруу үйлдлийг хатуу шийтгэдэг, чанга тогтолцоо байх ёстой юм болов уу гэж хувьдаа боддог. Найман зарчмын хувьд нэмэх зүйл юу байх вэ дээ.

► **Ерөнхийдөө ийм зарчим бол байх ёстой гэж үзэж байна уу?**

-Байх ёстой.

-Банкны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орж 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлнэ. Банкны засаглалыг сайжруулах, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг хуульд тусгаж өгсөн шүү дээ.

-Бидний хувьд засаглал маш чухал гэдгийг хавьгүй эрт ойлгосон. Гадны том байгууллагатай харьцдаг болохоор тэдний засаглалын стандартаар явдаг. Бидний баримталдаг гол зарчим юу гэхээр хувь нийлүүлэгчид нь банкны удирдлагатай зөвхөн ТУЗ-өөр дамжиж харьцдаг. Шууд харьцдаг тогтолцоо байхгүй. Энэ нь менежментийн хараат бус байдлыг хамгаална. Мөн ТУЗ-ийн хариуцлагыг өндөр түвшинд хүргэхэд чухал байсан болов уу.

► **Банкуудын өрсөлдөх чадвар. Банкны өрсөлдөөн аль субъект дээр байх ёстой юм бол. Хадгаламжийн хүү, зээлийн хүүн дээр үү?**

-Банк бол бизнес. Бид бүтээгдэхүүнээ борлуулж байгаа. Тэр бүтээгдэхүүний үнэ бол хүү.

Тэгэхээр гадны аль ч салбарын жишгийг харахад үнээр өрсөлдөж, үнийн дайнд оролцсон компани тэндээс амжилттай гарсан тохиолдол маш ховор байдаг. Тэгж байснаас өөрийнхөө өөр давуу тал юу вэ гэдгийг харилцагч, худалдан авагчдаа зөв харуулах нь чухал. Жишээлбэл, манай хүү манай өрсөлдөгчөөс 0.1 нэгжээр бага гээд явлаа гэхэд нөгөө өрсөлдөгч нэг мэдэхэд л хүүгээ адилхан бууруулчихна шүү дээ. Тэгэхээр энэ богино хугацааны өрсөлдөөн болно. Тэгвэл эсрэгээрээ зээл авах гэж байгаа хүний зээлийг хурдан, шуурхай шийдэж өгдөг, хүнд суртал чирэгдэл багатай байх. Бизнес чинь тохирсон зээлийг тохирсон нөхцөлөөр олгох ч юм уу. Төлбөрийн картан тал дээр илүү уян хатан, оноо цуглуулах ч юм уу. Барьцаа хөрөнгө дээр уян хатан тогтох гэх ч юм уу өөр талын өрсөлдөөн байж болно. Хадгаламжийн хүүгийн хувьд банкуудын өрсөлдөөн болон зохицуулалттай хамааралтай юм болов уу гэж хардаг. Том банкууд нь илүү бага хүү өгөхөд бэлэн байдаг. Жижиг банкууд яах аргагүй эх үүсвэрээ татахын тулд өндөр хүү амлахаас өөр аргагүй байдаг. Энэ зөвхөн Монголд ч биш, бусад улс оронд ч ийм л байдаг. Тэгэхээр энэ дээр Монгол Улсын хувьд 14 банк байх шаардлагатай юу, үгүй юу гэдэг асуудал. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлээ гэхэд тэдгээр банкууд байх уу, үгүй юу. Тэгэхээр эцсийн эцэст өрсөлдөөн шударга байх ёстой. Зах зээлийн зарчмаар байх ёстой. Бизнес стратегийн хувьд үнийн өрсөлдөөн биш. Бусад өрсөлдөөнөөр явагдах нь зөв. Дотооддоо ч бас бид бүтээгдэхүүнээ аль болох хямд өртгөөр гаргахыг боддог. Тэгэхээр эх үүсвэрийн зардал дээр бид онцгой анхаардаг. Аль болох хямд, бага өртөг эх үүсвэр татахыг боддог. Сүүлийн үед

банкуудын өрсөлдөөн маш хүчтэй болсон. Маркетинг дээр ч бас маш их төсөв тавьдаг болсон. Эдийн засаг хангалттай тэлээд, бизнесүүд өсч байх үед хоорондоо өрсөлдөх төдийлөн шаардлагагүй бүгдээрээ л хангалттай бизнестэй байсан. Одоо эдийн засаг хүндэрч байгаа үед зардлаа маш зөв хуваарилж, эрсдэлийн удирдлагаа маш өндөр түвшинд авч үзэх шаардлагатай болж байна.

► **Гадаадын банк орж ирэх тухайд та ямар байр суурьтай байдаг вэ. Зарим хүн бол гадны банк л ороод ирчихвэл бүх зүйл сайхан болно гэж яриад байгаа шүү дээ...?**

-Өрсөлдөөн нэмэгдэх нь мэдээж сайн. Гэхдээ нөгөө талаас гадны банк орж ирээд, шууд л маш бага хүүгээр зээл өгнө гэж байхгүй. Монгол Улсын зэрэглэл ямар байгаа билээ. Гадны банк орж ирлээ гэхэд Монгол Улсын эрсдэлийг хүлээн зөвшөөрөөд, тэр эрсдэлдээ тохирсон үнээр л бүтээгдэхүүнээ гаргана шүү дээ. Тэгэхээр тодорхой хэмжээнд дотоодын банкны зээлийн хүүгээс арай бага байж болно. Гэхдээ гадны банкныхаа стандартаар л явна шүү дээ. Тийм учраас гадны банк орж ирээд, шууд л зээлийн хүүг 50-60 хувиар бууруулаад явчихна гэж байхгүй. Мэдээж цаашдаа гадны банк орж ирэх л байх. Гэхдээ олон улсын жишгийг харвал гадны банк орж ирснээрээ үргэлж эдийн засаг нь тэлээд, амжилттай явж байгаагүй. Зүүн европын жишгийг харвал гадны банкууд орж ирээд, нэлээд алдагдал хүлээж, амжилтгүй байсан. Гэтэл зарим оронд амжилтанд хүрсэн түүх ч бас байгаа л даа харилцан адилгүй.

► **Ярилцсанд баярлалаа.**

БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИ БА КРИПТОВАЛЮТ

"Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүлийн 2017/01[04] дэх дугаараас...

Д.Довчинбазараар¹ ахлуулсан ажлын хэсэг

Нэр томъёо, тодорхойлолт

Блокчэйн:	Blockchain
DLT:	Тархсан бүртгэлийн дэвтэр буюу Distributed ledger technology
P2P сүлжээ:	Peer to peer network
Биткойн:	Bitcoin
Этереум:	Ethereum
CBDC:	Төв банкны дижитал мөнгө буюу central bank digital currency
Google trend:	Энэ нь google (нийт интернет хайлтын 64.0%)-ээр хийсэн аливаа үгэн хайлтын google-ийн нийт хайлт, болон бусад үгэн хайлтуудтай харьцуулах хэрэгсэл юм.

1. Блокчэйн технологи

Хамгийн анх блокчэйн технологийн талаар 2008 онд Сатоши Накамото² гэдэг этгээдийн нийтэлсэн "Биткойн: P2P электрон мөнгөний систем" судалгааны ажлын нийтлэлд дурдагдсан байдаг.

Тархсан P2P сүлжээ гэдэг нь сүлжээнд оролцогчид буюу зангилаанууд нь газарзүйн хувьд тархсан байдаг ба аль ч 2 зангилаа хоорондоо байршлаас үл хамааран ямар нэг серверээр дамжилгүйгээр өөр хоорондоо шууд холбогддог сүлжээ юм.

DLT технологи нь мэдээллийг тархсан P2P сүлжээний оролцогч нар дээр хадгалдаг технологи бөгөөд уламжлалт өгөгдлийн сангийн системээс ялгарах гол ялгаа нь төвлөрсөн өгөгдлийн сан болон төвлөрсөн удирдлагын функц байхгүйд оршино.

¹ Мэдээллийн технологийн газрын захирал. Цахим шуудан: dovchin@mongolbank.mn

Ажлын хэсгийн гишүүд: МБГ-ын ЭЗШБХ-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Түмэнцэнгэл; ТТГ-ын захирал Э.Анар; ЭУА-ны захирал Н.Мөнхдалай; МТГ-ын ПХБА-ын ахлах мэргэжилтэн О.Бямбадорж; ТТГ-ын УАХ-ын ахлах мэргэжилтэн; МБГ-ы МБТХ-ын эдийн засагч А.Ганбат; ССГ-ын СуХ-ын эдийн засагч Д.Цэнддорж; ТТГ-ын БЗУАХ-ийн мэргэжилтэн А.Бат-Оргил; ЭУА-ны эдийн засагч Д.Оюунтүлхүүр; НУСЗГ-ын ГВУНУХ-ын нөөцийн мэргэжилтэн А.Энхтүвшин; Дижитал экскенж ХХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Лхамсүрэн;

² Хүн эсвэл байгууллага гэдэг нь тодорхойгүй

Блокчэйн гэдэг нь DLT технологийн гол төлөөлөгч бөгөөд мэдээллийн гинжин хэлхээ юм. Блокчэйнд тогтсон хэмжээтэй блок үүсгэн үүн дотроо мэдээллийг хадгалах ба эхний блок дүүрэхэд дараагийн шинэ блок үүсгэдэг. Эдгээр блокууд нь хэйш функцээр кодлогдсон байх ба блокийг цаг хугацааны дагуу жагсааж, блок тус бүр яг өөрийн өмнөх блокийн мэдээллийг өөр дотроо хадгалах байдлаар гинжин бүтцийг үүсгэнэ.

Блокчэйн технологийн хамгийн чухал, онцлох давуу тал нь төвлөрсөн бус тархсан бүтэцтэй бөгөөд сүлжээнд байгаа бүх компьютер блокчэйний халдашгүй чанарыг үргэлж баталгаажуулж байдаг ба хэн нэгэн эсвэл аль нэг компани үүн доторх өгөгдөл түүний бүрэн бүтэн байдлыг удирдах боломжгүй байдаг байгаа юм.

Блокчэйн технологи нь хөгжлийн эхний шатандаа явж байгаа тул цөөнгүй сорилт, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд бий. Технологийн хувьд, институцийн хувьд, хууль эрх зүйн орчны зохицуулалтын хувьд блокчэйн технологийн потенциалыг бизнест, эдийн засагт бүрэн нэвтрүүлж, үр өгөөжийг нь хүртэхэд дараах гол сорилтууд тулгарч байна:

- Тархсан сүлжээнд хяналт баталгаажуулалтыг хурдтай хийхэд өндөр хурдтай тооцоолон бодох чадвартай компьютер, их хэмжээний дата хадгалах сервер, тэдгээрийг ажиллуулах эрчим хүч шаардлагатай. Эдгээр зүйлсэд оновчтой шийдэл олоогүй цагт блокчэйн технологи олон салбарт нэвтэрч, өргөн тархах боломж хязгаарлагдмал юм. Ялангуяа их хэмжээний эрчим хүчний хэрэглээ нь дэлхийн дулаарлын эсрэг олон улсын гэрээ, конвенцуудтай хэрхэн уялдах нь тодорхой бус байна.
- Тухайн гүйлгээ буюу мэдээллийн үнэн зөв эсэхийг сүлжээний нийт оролцогч нийтээр баталгаажуулж байгаа нь блокчэйний хэмжээ томрох тусам улам их цаг хугацаа, эрчим хүч шаардана. Блокчэйний хэмжээ томрох тусам сүлжээний нийт оролцогч бүр дээрх мэдээллийг яг адил байлгах нь бэрхшээлтэй тулгарна.
- DLT ашигласан системд хяналтыг хэрхэн тавих нь тодорхойгүй байна. Аль нэг хяналтын

байгууллагад тухайн системд хяналт хийх эрх өгөгдсөн тохиолдолд тухайн байгууллага нь халдлагын бай болж болох бөгөөд хяналтын хэрэгсэл, нууц түлхүүр алдагдвал системийн нийт мэдээлэл эрсдэлд орно.

- Блокчэйн технологи амьдралд нэвтрэхийн хэрээр хувийн мэдээлэл цахим орчинд их хэмжээгээр байрших болж, кибер аюулгүй байдлын асуудлууд улам хүчтэй тавигдах болно. Энэ үед мэдээллийн нууцлал алдагдахгүй байх, хакерийн үйл ажиллагаанаас сэргийлэх сайн шийдэлгүй байх нь уг технологи өргөн нэвтрэх боломжид саад учруулах эрсдэлтэй.
- Блокчэйн аливаа салбарт нэвтрэхийн хэрээр технологийн нэгдсэн стандарт, эрх зүйн орчны баримтлах нийтлэг дүрмүүд, зохицуулалт зэрэг хэм хэмжээ тодорхой болох шаардлагатай. Харин одоогийн байдлаар нэгдсэн хууль дүрэм, мөрдөх стандарт алга байна.

Эдийн засгийг тулгуураар нь өөрчлөх потенциалтай сүүлийн үеийн технологи нь DLT гэж зарим мэргэжилтнүүд үзэж байна. Технологи санхүүгийн тогтолцоог хурдацтай өөрчилж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, арга барилыг нэвтрүүлж буй тул зохицуулагч нарын хувьд ч тэр, бизнесийн байгууллагуудын хувьд ч тэр финтек чухал сэдэв болсон.

DLT нь мэдээллийг хурдтай, хямд дамжуулахаас гадна аюулгүй байдал, нууцлалыг өндөр түвшинд хадгалах боломжийг олгож буй. Блокчэйн технологи бизнесийн олон салбарт инновацийг бий болгох боломжтой гэгдэж буй. Дундын зуучлагчийг халж, төвлөрсөн бус нээлттэй орчинд мэдээллийн дамжуулалт, хяналт баталгаажуулалт, хадгалалтыг хийдэг энэхүү технологи гүйлгээ, шилжүүлэг явуулах процесс, бүртгэл хадгалалт, тэдгээрт тавих хяналт зэргийг үндсээр нь өөрчлөх онцлогтой.

2. Криптовалют хэрэглэгчдийн байдал: Монголд


2.1. Биткойн

Монгол улсад криптовалют, финтекийн талаар хийсэн нэгдсэн тоо баримттай судалгаа одоогоор байхгүй байгаа бөгөөд тайлангийн энэ хэсгийг тандах, сурвалжлах хэлбэрээр олсон тоо, мэдээлэлд үндэслэн боловсрууллаа.

Монгол Улсаас Google-ийг ашиглаж хийсэн "bitcoin" гэсэн хайлтын давтамж 2017 оны дунд үеэс эхлэн огцом нэмэгдсэн бөгөөд 2017 оны 11 дүгээр сард хайлтын тоо

нь "ханш"-ын талаар хийсэн хайлтаас давсан байна. Энэ нь манай улсын иргэд биткойний талаар ам. долларын ханшнаас ч илүү сонирхож байгааг илтгэх бөгөөд дэлхийд ч мөн адил 2017 оны 5 дугаар сараас эхлэн буюу биткойний ханш огцом өсөж эхэлснээс сар орчмын дараа google хайлт огцом нэмэгджээ. Манай улсад биткойний талаарх хайлтын дүн нь нэмэгдэж байгаа хэдий ч түүний суурь технологи блокчэйн талаарх хайлтын дүн төдийлөн их биш (8 дахин бага), бусад криптовалютын талаарх хайлт ч мөн адил их биш байгаа нь биткойний талаарх энэхүү сонирхол нь үнийн өсөлтөөс шалтгаалсан үзэгдэл болохыг харуулж байна.

Дүрслэл 1.



Эх сурвалж: Google (25.12.2017)

*Тэмдэглэл: Харьцуулж буй үзүүлэлтүүдээс хамгийн өндөр утгатай нь 100 байх бөгөөд бусад үзүүлэлтүүдийг хамгийн өндөр үзүүлэлтэд харьцуулан гаргана.

Дэлхийн хэмжээнд биткойний сонирхол ихээхэн нэмэгдэж, мөргөж, форекс зэрэг түгээмэл хайлтуудаас хол давсан бөгөөд 2017 оны 12 дугаар сараас эхлэн алтнаас илүү их хайлт хийж, автомашины талаарх хайлттай ойролцоо болж нэмэгджээ.

Хүснэгт 1.

Хамгийн их хайлт		Өндөр өсөлттэй хайлт	
bitcoin price	100*	bitcoin price usd	Breakout (маш өндөр)
bitcoin to usd	70	bitcoin calculator	Breakout (маш өндөр)
bitcoin mining	40	bitcoin mongolia	Breakout (маш өндөр)
bitcoin price usd	35	bitcoin rate	Breakout (маш өндөр)
bitcoin wallet	30	bitcoin difficulty	Breakout (маш өндөр)
bitcoin calculator	30	bitcoin price	130%
bitcoin гэж юу вэ	25	bitcoin wallet	50%
bitcoin miner	15		
bitcoin mongolia	15		
free bitcoin	10		
what is bitcoin	10		
bitcoin rate	5		
bitcoin difficulty	5		

Монгол Улсад биткойний талаарх хайлт өнгөрсөн

12 сарын хугацаанд 600%-ийн өсөлттэй буюу хамгийн их нэмэгдсэн үзүүлэлт болсон бөгөөд үүнд биткойний үнийн талаарх хайлтууд хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Хүснэгт 1). Мөн анхаарал татаж байгаа нэг зүйл бол биткойн олборлох талаар хийж буй (bitcoin mining, bitcoin miner, bitcoin difficulty) хайлтууд байна. Эдгээрээс "bitcoin difficulty" гэсэн хайлт нь биткойн олборлох асуудлыг харьцангуй ахисан түвшинд судалж байгаа хүмүүсийг илтгэж болох бөгөөд тэдгээр нь нийт биткойн сонирхсон хайлтын 1.3% байна. Харин "bitcoin mongolia", "bitcoin wallet" хайлтыг хийсэн иргэд худалдан авах сонирхолтой буюу хөрөнгө оруулалт хийх сонирхолтой иргэд (биткойнтой холбоотой нийт хайлтын 11.5%) байж болох юм.

Мөн үүнээс илүү сонирхолтой баримт нь сүүлийн нэг жилд биткойнтой холбоотой хайлтын ихэнх нь Өмнөговь аймагаас хийгдэж байгаа бөгөөд Улаанбаатар хот нь Өмнөговь аймгийн 25.0%, Орхон аймаг 37.0%-тай тэнцэж байна. Уул уурхайн том ордууд бүхий 2 хотын хүн ам Улаанбаатар хотынхоос хэд дахин бага хэдий ч биткойний талаар хийсэн хайлтын давтамж хэд дахин өндөр байна.

3. DLT-г төлбөрийн системд ашиглах нь

DLT нь олон салбарын үйл ажиллагаанд ашиглагдах бололцоотой нь өдөр бүр батлагдаж байгаагийн дотор санхүүгийн салбар тэр дундаа төлбөр тооцооны системд нэвтрэх бололцоотой хэмээн үзэж дэлхийн хэд хэдэн санхүүгийн төвүүд, гарааны бизнес эрхлэгч финтек компаниуд хамтран туршилтууд хийсээр байна.

DLT-г үндэсний төлбөрийн системд нэвтрүүлснээр үүсэх давуу тал, үр ашиг:

Одоогийн төлбөрийн системээр дамжиж буй аливаа гүйлгээ нь төв банкны системээр дамжин хийгддэг ба гүйлгээний мэдээлэл нь зөвхөн төв банк дээр бүртгэгддэг бол DLT-г нэвтрүүлснээр аливаа гүйлгээ нь оролцогч тус бүрийн баталгаажуулалтад үндэслэгдэн хийгдэж, гүйлгээний бүх мэдээлэл дундын дэвтэр хэлбэрээр хадгалагддаг ба төлбөрийн системийн оролцогч тус бүр тухайн мэдээллийг хянаж байх боломжтой. Энэхүү онцлог нь төлбөрийн системийн тасралтгүй найдвартай ажиллах гэсэн шаардлагыг одоогийн дэд бүтцээс илүү хангах боломжтой. Түүнчлэн, оролцогчдын мэдээллийн нууцлалыг хадгалахын тулд дундын цахим дэвтэрт тусгагдсан нууцлах шаардлагатай мэдээллийг харах боломжгүй байдлаар шийдэх боломжтой юм.

DLT-г үндэсний төлбөрийн системд нэвтрүүлснээр үүсэх сул тал:

Этереум дээр туршсан дундын цахим дэвтэрт мэдээллийг шинэчлэх үйл явц нь 'proof-of-work' зарчимд суурилсан буюу системийн оролцогч бүр гүйлгээг баталгаажуулах шаардлагатай байдаг учраас төлбөр тооцооны эцэслэлт хийгдэхэд хүндрэлтэй, цаг хугацаа их шаардсан процесс юм. Харин "Jasper phase 2" буюу Канадын төв банкны хэрэгжүүлсэн төслийн 2 дахь шатны ажиглалтаар "Corda platform" дээр хийгдсэн гүйлгээ нь этереумтэй харьцуулахад их хэмжээний гүйлгээг саадгүй дамжуулах, баталгаажуулах боломжтой хэдий ч үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах шаардлагад нийцэхгүй буюу дахин үргэлжлүүлэн судлах шаардлагатай гэсэн байна.

4. Блокчэйн ба Эдийн засаг

4.1. Санхүүгийн секторт бий болгох инноваци

Блокчэйн технологийн бий болгож буй инноваци нь мөнгөний талаарх ойлголтыг өөрчлөх боломжтой. Эдийн засагт мөнгө нийлүүлэгдэх процесс, төлбөр тооцоо болон шилжүүлэг, гуйвуулга хийгдэж баталгаажих явцыг шинэчлэхээс гадна шинэ төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслийг бий болгох боломжийг блокчэйн технологи үүсгээд байна. Цаашид технологийн найдвартай байдал, зах зээлд хэрэглэгчдийн тоо өсөхийн хэрээр ийм төрлийн дижитал мөнгөний эдийн засагт гүйцэтгэх үүрэг роль ч ихсэх боломж бий.

Санхүүжилт татах, хөрөнгө босгох үйл явцыг блокчэйн технологи өөрчилж байна. Блокчэйн технологи нь олон зээлдүүлэгч оролцдог синдикат зээлийг судлах, зээлдэгчийн эрсдэлийг тодорхойлох, санхүүжилтийг олгох, хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хуваарилах гэх мэт процессийг хялбарчлах боломжийг олгож буй. Тус технологийн ил тод байдал нь эдгээр процессийг хянах хяналтыг нээлттэй болгож буй. Мөн токен (дижитал зоос) санал болгох замаар хөрөнгө оруулалт татах арга (Initial coin offering буюу ICO) нь кровдфанд хэлбэрээр хөрөнгө оруулалт татах нэгэн шинэ арга зам болон хөгжиж байна.

4.2. Төв банкны үйл ажиллагаанд үзүүлэх боломжит нөлөө

Блокчэйн технологийн авчрах өөрчлөлтүүдэд төв банкууд бэлтгэлтэй байх нь чухал. Хэдийгээр блокчэйн технологи, түүн дээр суурилсан криптовалютууд зах зээл дээр хараахан өргөн хэрэглээ болоогүй байгаа ч цаашид үүсэж болох эрсдэл болон боломжуудад зохицуулагч байгууллагууд, тэр дундаа төв банкууд бэлтгэлтэй байх нь чухал. Блокчэйн технологийн нөлөөгөөр мөнгөний хэлбэр дүрс, мөнгө

эдийн засагт нийлүүлэгдэх арга зам, төлбөр тооцоо хийгдэх зарчим сууриараа өөрчлөгдөж, төвлөрсөн бус шинж чанартай болох нь өдийг хүртэл төв банкны эдийн засагт гүйцэтгэж ирсэн үүрэг рольд нөлөө үзүүлэх боломжтой.

Шинэ технологийг хуучин дүрмээр зохицуулах аргагүй ч, хөгжлийнхөө анхан шатанд яваа тул шинэ зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд эрт байна. Блокчэйн технологи, түүн дээр суурилсан криптовалютууд нь хөгжлийн эхний шатандаа яваа бөгөөд хэрхэн яаж оновчтой зохицуулалт хийх вэ гэдгийг тодорхойлоход эрт байна. Криптовалют хэрэглэгчдийн тоо, криптовалютуудын мөнгөн дүн нь системийн эрсдэл үүсгэх хэмжээнд хараахан хүрээгүй тул төв банкууд ч тэр, бусад зохицуулагч нарт ч тэр ажиглах байр суурь давамгайлж байна.

Блокчэйн технологи дээр суурилсан дижитал мөнгийг төв банкууд гүйлгээнд гаргах талаарх санаа мэтгэлцээний түвшинд байна. Орчин үед эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийн дийлэнх хэсэг бэлэн бус хэлбэрээр орших болсон тул төв банкууд мөнгөн тэмдэгтийг орлох CBDC-ийг гүйлгээнд гаргах тухай асуудал онолын түвшинд яригдахаас гадна, зарим улс орнууд туршилт, судалгаа хийж байна.

CBDC нь мөнгөний бодлогын нөлөөг өөрчлөх, магадгүй сайжруулах боломжтой. Блокчэйн технологи нь данс хоорондын шилжүүлэг гүйлгээг хурдан, хямд гүйцэтгэх боломжийг олгосноор төв банк олон тооны аж ахуйн нэгж, иргэдтэй шууд харилцах боломжийг бүрдүүлж буй. Иймд банк бус санхүүгийн байгууллага, бусад ААН, иргэдэд зориулсан дижитал дансыг төв банкин дээр нээн нөөц мөнгийг бүрдүүлэх боломжтой болгох талаар зарим судлаачид, төв банкны удирдлагууд дурдах болсон. Төв банк мөнгөн тэмдэгтэй 1:1 харьцаагаар хөрвөх дижитал мөнгийг гарган, данс хоорондын гүйлгээг блокчэйн технологиор хийнэ. Дижитал мөнгөнд хүү тооцсоноор банк санхүүгийн байгууллагаар дамжихгүйгээр эдийн засгийн идэвхжилд илүү үр дүнтэй нөлөөлж, мөнгөний эргэлтийг оновчтой удирдах боломж бий болно гэдэг үзэл бодол ч урган гарч ирж буй.

Жич: Биткоин болон бусад криптовалюта нь харьцангуй өндөр эрсдэлтэй тул Монголбанкнаас хуримтлал үүсгэх санхүүгийн хэрэгсэл гэж үзэхгүй ба төлбөр тооцооны хэрэгсэл гэж баталгаажуулаагүй болно.



ТА САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ БОЛОХЫН ХУВЬД ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХДАА ЮУНД АНХААРАХ ВЭ?

Зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнө сайн уншиж танилцан, ойлгохгүй бол тайлбарлуулах эрхтэй.

1. Зээлийн гэрээ гэж юу вэ?

Банкууд зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг нийтэд санал болгож мэдээлдэг. Зээлийн гэрээг бичгээр байгуулах ба мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээдэг.

2. Гэрээнд гарын үсэг зурахдаа юуг анхаарах вэ?

Зээлдэгч нь гэрээнд гарын үсэг зурахаас өмнө гэрээг сайн унших хэрэгтэй ба ойлгохгүй зүйл, заалт байвал банкны ажилтнаар сайтар тайлбарлуулах эрхтэй. Яаран сандран гарын үсэг зурж болохгүй. Нөгөө талаас банкууд харилцагчдад хугацаа өгч, зээлийн гэрээтэй сайтар танилцах боломжийг өгч байх ёстой. Нэгэнт гэрээнд гарын үсэг зурж зээл авсан бол тэр гэрээ нь хүчин төгөлдөр болно гэсэн үг юм. Монголбанк талууд харилцан тохиролцон байгуулсан гэрээг өөрчлөх эрх байхгүй. Иймд банк ч тэр зээлдэгч ч мөн адил өөрийн санхүүгийн зан байдал, орлого, эргэн төлөх хуваарьт хугацаа зэргийг сайн тооцох хэрэгтэй. Зарим тохиолдолд зээл олгохгүй байх нь зээлдэгчийн төлөө шийдвэр ч байж болно.

3. Гэрээний гол нөхцөлүүд ямар байх ёстой вэ?

Ямар ч гэрээнд гэрээний хугацаа, хүү, нэмэгдүүлсэн хүү тооцох болон зээлийн эргэн төлөлт, зээлийн хугацаа хэтрүүлбэл хүлээх хариуцлага, барьцаа хөрөнгөөр зээл, хүү, нэмэгдүүлсэн хүү болон бусад зардлыг багтаан төлүүлэх асуудал заавал тусгагддаг.

4. Зээл хугацаандаа төлөхгүй байх болон төлж чадахгүй бол яах вэ?

Энд хэд хэдэн үр дагавар үүсдэг. Санхүүгийн болон амьдралын хэвийн нөхцөл алдагдана. Зээлдэгч авсан

зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй байдаг. Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлнэ. Мөн хөдлөх эд хөрөнгөнд үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй байдаг. Мөн зээлийн түүх нь Зээлийн мэдээллийн санд буюу тухайн хүний зээлийн түүхэнд тэмдэглэгдэн үлдэнэ.

5. Зээлийн мэдээллийн санд бүртгэгдэнэ гэж юу гэсэн үг вэ?

Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээл олгогч байгууллага зээлдэгчийн мэдээллийг түүний зөвшөөрөлтэйгээр Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх үүргийг хүлээсэн байдаг. Зөвшөөрөлтэйгээр гэдэг нь зээлийн гэрээнд заавал тусгагддаг заалт бөгөөд энийг зээлдэгч нар төдийлөн анзаардаггүй. Ерөнхийдөө зээлийн мэдээллийн сан гэдэг нь зээлдэгч гэрээний үүргээ тухай бүр биелүүлсэн тохиолдолд банк санхүүгийн байгууллага найвдартай зээлдэгч байна гэж үзэн зээлийн хэмжээ өндөр, хүү бага, урт хугацааны зээл олгох шийдвэр гаргахад нөлөөлдөг. Харин үүргээ биелүлдэггүй зээлдэгчийн мэдээллийг бүртгэснээр банк эрсдэлтэй зээлдэгч гэж үзэн зээл олгохгүй байх шийдвэр гаргах магадлалтай болдог. Гэхдээ энэ нь огт зээл олгохгүй гэсэн үндэслэл биш бөгөөд тухайн банк, зээл олгож буй газрын харилцагчаа үнэлэхэд л ашиглагдаж буй мэдээлэл юм.

Зээлийн мэдээллийн санд мэдээлэл бүртгэгдэнэ гэдэг бол тухайн хүний зээлийн түүхийн мэдээлэл бөгөөд зээл авч байсан байдал, хугацаандаа төлсөн бол хэвийн төлөгдсөн, хэрэв хугацаа хэтэрсэн бол зээлийн ангилалаар мэдээлэл нь бүртгэгддэг. Зээлийн ангилал нь хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэж хуваагддаг.



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31



Олон улсын хэрэглэгчийн
эрхийг хамгаалах өдөр



Зорилт

- Санхүүгийн хэрэглэгчдэд чиглэсэн суурь мэдлэг олгож, эрх үүрэг, хариуцлагыг ойлгуулан, гарч болох эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах чадвар суулгахад чиглэнэ.

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаарх мэдээллийг санхүүгийн хэрэглэгч буюу иргэд-харилцагчдад олгож, хүртэж болох ашиг, үүсэж болох эрсдэл, бусад нөхцөлийг үнэн зөв, ойлгомжтой тайлбарладаг болгоход зорино.

Хамрах хүрээ



- 18 буюу түүнээс дээш насны санхүүгийн харилцаанд оролцож буй иргэд,
- Санхүүгийн харилцаанд орж эхлэх гэж буй залуу үеийнхэн.



Чиглэх ажил

- Иргэд санхүүгийн чадамжаа зөв тодорхойлоход дэмжлэг үзүүлэх,
- Санхүүгийн эрсдэлийг урьдчилан харах,
- Өргөн хэрэглээний санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой суурь ойлголтуудыг олгох.

Хэрэгжилт



Банк санхүүгийн байгууллага

- Хууль, эрх зүйн боломж, өөрийн эрх үүргийн талаарх ойлголт өндөр байдаг.
- Нөөц бололцоогоор баялаг байдаг.
- Бүтээгдэхүүнийхээ талаар бүрэн мэдлэг мэдээлэлтэй байдаг



Хэрэглэгч

- Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэг бага байдаг.
- Өөрийн эрх үүргийн талаар ойлголт хомс байдаг.
- Санхүүгийн боловсролын хүрээнд мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг.



MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA

Монголбанк

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5.7 дахь хэсэгт "банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэсэн нэмэлт өөрчлөлт орсон.
Тус өөрчлөлтөөр хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх эрх Монголбанкинд олгогдсон.



Үр дүн

Монгол Улсын хууль тогтоомж болон зохицуулалтын хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн хэрэглэгчийн хооронд үүсэх мэдээллийн тэнцвэргүй байдлыг арилгах, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалж санхүүгийн тогтвортой байдлыг хангах хууль эрх зүйн орчны эхлэлийг тавьж, шинэ хууль батлуулна.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аяны талаарх мэдээллийг дараах хаягаар авна уу.



www.mongolbank.mn



sankhuuginbolovsrol.mn



@mongolbank_mn



@mongolbank_mn



mongolbank



11-328298



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



MBA
MONGOLIAN BANKERS ASSOCIATION



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Credit Insurance Corporation of Mongolia



MONGOLIAN MORTGAGE CORPORATION
МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН



ADB



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31